



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2020 • 08 • № 48

Б.БАЯРДАВАА:

МОНГОЛБАНК ЭДИЙН
ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ ХАНГАХАД
ЧИГЛЭСЭН БОДЛОГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

МӨНГӨН
ТЭМДЭГИЙН
СОЁЛТОЙ
ХЭРЭГЛЭЭ НЬ
ОЛОН ТАЛЫН АЧ
ХОЛБОГДОЛТОЙ



ХАЛХ ЭХНЭРИЙН АЛТ ШАРМАЛ, ПААЛАН ГҮЙЛГЭСЭН ТАВАН САВААГҮЙ

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЛЭЭНД



МӨНГӨН ТЭМДЭГТИЙГ:

**"ХАЛААСАНД БУС
ХЭТЭВЧИНД,
ОВООНД БУС
ХЭРЭГЛЭЭНД"**

ЗӨВ, ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ.

WWW.MONGOLBANK.MN





04

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

МОНГОЛБАНК
БОЛОН ХЯТАДЫН
АРДЫН БАНК
ХООРОНД
БАЙГУУЛСАН
СВОП ХЭЛЦЛИЙН
ХУГАЦААГ СУНГАЛАА



17

НИЙТЛЭЛ


НОГООН
ТАКСОНОМИЙН
АНГИЛАЛ 7:
“ТОГТВОРТОЙ
ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ГАЗАР АШИГЛАЛТ,
ОЙ БОЛОН
ЭКО АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ”



07

ЯРИЛЦЛАГА:

Б.БАЯРДАВАА:
МОНГОЛБАНК
ЭДИЙН ЗАСГИЙН
ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ
ХАНГАХАД
ЧИГЛЭСЭН
БОДЛОГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЖ
БАЙНА



22

ДЭЛХИЙН ЭДИЙН
ЗАСАГ

КОВИД-19 ЦАР
ТАХЛЫН БАНКНЫ
СЕКТОРТ БИЙ
БОЛГОЖ БАЙГАА
ӨӨРЧЛӨЛТ



20

МОНГОЛБАНК
ЮУ ХИЙДЭГ ВЭ?

МӨНГӨН
ТЭМДЭГТИЙН
СОЁЛТОЙ
ХЭРЭГЛЭЭ НЬ
ОЛОН ТАЛЫН АЧ
ХОЛБОГДОЛТОЙ



29

БАНКИР:

**БНХАУ-ЫН
АРДЫН БАНКНЫ
ТЭРГҮҮН ИЙ ГАНГ:**
САНХҮҮГИЙН
САЛБАРЫН
ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ ХАНГАЖ,
БИЗНЕСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ
ДЭМЖИХЭД
АНХААРАЛ
ХАНДУУЛНА



33

СУДАЛГАА,
ШИНЖИЛГЭЭ

ТӨВ БАНКНЫ
ЗАСАГЛАЛ:
ЕВРОПЫН ТӨВ
БАНК БОЛОН
ХБНГУ-ЫН
ТӨВ БАНКНЫ
ТУРШЛАГА

2020 ОНЫ 8 ДУГААР САРЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

2020.08.03

МОНГОЛБАНК БОЛОН ХЯТАДЫН АРДЫН БАНК ХООРОНД БАЙГУУЛСАН СВОП ХЭЛЦЛИЙН ХУГАЦААГ СУНГАВ



Монголбанк, Хятадын Ардын банк хооронд байгуулсан төгрөг-юанийн своп хэлцлийг 2020 оны долоодугаар сарын 31-ний өдөр шинэчлэн байгуулж, своп хэлцлийн гэрээг дахин 3 жилээр сунгалаа. Ингэснээр энэ онд төлөгдөх ёстой байсан 2 орчим тэрбум ам.долларын төлбөрийн асуудлыг шийдэж, валютын нөөцөд ирэх сөрөг дарамтыг хойшлуулаад байна. Монголбанк 2011 онд хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих зорилгоор Хятадын Ардын банктай 10 тэрбум юантай тэнцэх хэмжээний үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийг байгуулсан юм. Уг хэлцлийн хугацааг 2014 онд дахин 3 жилээр сунгаж, дүнг 15 тэрбум юань болгон нэмэгдүүлсэн бол 2017 онд хэлцлийн хугацааг мөн 3 жилээр сунгаад байсан юм.

Монголбанк, Хятадын Ардын банк хооронд байгуулсан төгрөг-юанийн своп хэлцлийг 2020 оны долоодугаар сарын 31-ний өдөр шинэчлэн байгуулж, своп хэлцлийн гэрээг дахин 3 жилээр сунгалаа. Ингэснээр энэ онд төлөгдөх ёстой байсан 2 орчим

2020.08.10

"ХАЛААСАНД БУС ХЭТЭВЧИНД, ОВООНД БУС ХЭРЭГЛЭЭНД" АЯНЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ



дэлхийн бусад улс орны мөнгөн тэмдэгттэй харьцуулахад хангалтгүй үзүүлэлт юм. Иргэд мөнгөн тэмдэгтийг зөв зохистой хэрэглэдэггүй, хэтэвч ашиглахгүйгээр, халаасандаа олон нугалж хийдэг, түүнчлэн бага мөнгөн тэмдэгтийн хувьд төлбөрийн хэрэгсэл гэхээсээ илүүтэй бурхан тахил, уул овоонд өргөх байдлаар зүй бусаар ашигладаг зэрэг нь төгрөгийн насжилтыг багасгах үндсэн шалтгаан болдог байна.

Иймд үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг улс үндэстний тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг, үнэт цаасных нь хувьд зүй зохистой ашиглахыг уриалж, олон нийтэд сурталчлан таниулахад уг аяны зорилго оршиж буй. Аян 8 дугаар сарын 10-наас 10 дугаар сарын 1-нийг дуусталх хугацаанд хэрэгжинэ.

Монголбанкнаас санаачлан үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн зөв зохистой хэрэглээг дэлгэрүүлэх, мөнгөн тэмдэгтийн насжилтыг уртасгах зорилгоор "Халаасанд бус хэтэвчинд, овоонд бус хэрэглээнд" аяныг эхлүүлээ. Судалгаагаар Монгол төгрөгийн насжилт дунджаар 3.8 жил байгаа нь

2020.08.21

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДАД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛОО

Монголбанкнаас Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан финтек компанид төлбөрийн үйлчилгээний зөвшөөрлийн гэрчилгээг гардууллаа. Хөдөлгөөнт банкны процессорын зөвшөөрлийг "МОСТ Финтек" ХХК-д, төлбөрийн картны процессорын зөвшөөрлийг "М чат" ХХК-д тус тус олгов.



Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван эдгээр байгууллагуудад зөвшөөрөл гардуулах үеэр “Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журмыг чанд сахин мөрдөж, хэрэглэгчийн эрх ашигт нийцсэн төлбөрийн үйлчилгээг нэвтрүүлэн, нууцлал аюулгүй байдлыг хангаж түргэн шуурхай, найдвартай ажиллаарай” хэмээв.

2020.08.26

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН 14 ДЭХ ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАВ



Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн 14 дэх дугаарыг Монголбанкнаас боловсруулан олон нийтэд хүргэлээ. Уг тайланд Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн эрсдэл, эмзэг байдал, Ковид-19 цар тахлын Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөлөл, Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарын голлох эрсдэл, эмзэг байдал, Монголбанкнаас хэрэгжүүлж буй макро зохистой бодлогын арга хэмжээний тухай нийт дөрвөн бүлэг багтсан байна. Энэ удаагийн тайланд Монгол Улсын санхүүгийн системийн эрсдэл, эмзэг байдлыг тодорхойлж, түүнийг хязгаарлахад чиглэсэн арга хэмжээ, Монгол Улсын санхүүгийн салбарын эрсдэл даах чадвар, цаашид санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй талаарх асуудлуудыг тусгасан нь өмнөх тайлангуудаас онцлог болсон. Тус тайланг Монголбанкны цахим хуудасны “Санхүүгийн тогтвортой байдал” цэснээс татан авах боломжтой.

2020.08.27

ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИЙГ БАТАЛЛАА



УИХ-ын ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаар “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай УИХ-ын тогтоол”-ыг баталлаа. УИХ-аас батлагдсан тогтоолын дагуу Монголбанк, СЗХ, Засгийн газар, УИХ хамтран ирэх 4 жилийн хугацаанд зээлийн хүүг 4 нэгж хувиар бууруулж, сарын 1 хувьд хүргэх талаар бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх юм. Банкны зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн 4 жилийн хугацаанд 20.6 хувиас 5 нэгж хувиар буурч, 2020 оны 7 дугаар сарын байдлаар 15.8 хувьд хүрээд байна. Цаашид зээлийн хүүг бууруулахдаа зээлийн хүүг өндөр тогтоход нөлөөлж буй эх үүсвэрийн зардал, банкны үйл ажиллагаа нь зардал болон банкны эрсдэлийн сангийн зардлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тогтоолын төслийг боловсруулах, батлуулах үйл явцад Монголбанк, СЗХ ажлын дэд хэсэгт орж, холбогдох тооцоо, судалгааг бэлтгэн хамтран ажиллав.



Б.БАЯРДАВАА

МОНГОЛБАНК ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваатай сүүлийн үед эдийн засагт гарч буй өөрчлөлтийн талаар ярилцлаа.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн нөхцөл байдал таагүй байна. Олон улсын эдийн засгийн байдал, гадаад орчныг хэрхэн дүгнэж байна вэ?

Дэлхийн эдийн засаг цар тахлын нөлөөгөөр 2020 онд -5 орчим хувийн агшилттай байх төсөөллийг олон улсын байгууллагууд хийсэн. Хөгжсөн орнуудад -8 хувийн агшилт бий болох бол хөгжиж буй орнуудын хувьд агшилт -3 хувь байхаар хүлээгдэж байна. Харин БНХАУ-ын эдийн засаг энэ онд 1-2 орчим хувийн өсөлттэй байх төлөвтэй. Хятадын эдийн засагт өнгөрсөн 2-р улирлаас сэргэлт ажиглагдаж, ялангуяа сүүлийн 1-2 сард аж үйлдвэр болон үйлчилгээний салбарт нь эерэг өөрчлөлтүүд ажиглагдлаа. Гэхдээ гадаад эрэлтийг нь тодорхойлж буй АНУ, Евро бүсийн эдийн засаг хүнд хэвээр байна. Олон улсад Ковид-

19-ийн тархалт хэзээ намжих нь тодорхойгүй байгаа тул дэлхийн эдийн засаг, түүхий эдийн зах зээл дээр тодорхой бус байдал үргэлжлэх эрсдэлтэй.

Монголбанк эдийн засгийн цаашдын төлөвийг хэрхэн тооцоолж байна вэ?

Дотоод эдийн засгийн хувьд 2-р улиралд дотоодын нийт бүтээгдэхүүн бодит дүнгээр 9 хувийн агшилттай байсан нь Монголбанкны хүлээлт болох -7 хувиас давсан үзүүлэлт байлаа. Өөрөөр хэлбэл, цар тахал, түүний эдийн засагт үзүүлэх шууд болон шууд бус сөрөг үр дагавар хүлээж байснаас өндөр байна. Энэ нь өмнөх улиралд -1 хувь гэж тооцоолж байсан 2020 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг энэ улиралд бууруулж шинэчлэх шалтгаан боллоо. Эдийн засгийн өсөлтийн

төсөөллийг шинэчлэхдээ Ковид-19 цар тахлын дэгдэлт, түүний үргэлжлэх хугацаа, дотоодод хорио цээрийн арга хэмжээ сунгагдах эсэх зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзнэ. Эдийн засгийн идэвхжил суларснаар инфляци сүүлийн 4 сар дараалан буурч, 2020 оны 7 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 3.4 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 3.2 хувь байна. Энэхүү хандлага 2020 оны эцэс хүртэл хадгалагдах төлөвтэй бөгөөд эрэлтийн болон нийлүүлэлтийн аль аль талын хүчин зүйлс нөлөөлж байна. Төсвийг авч үзвэл орлого тасалдаж байгаа нь цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээг санхүүжүүлж хүрэлцэхгүйд хүргэж байна.

Валютын урсгал экспортын орлогын бууралтаас хамааран саарахын зэрэгцээ энэ жилийн хувьд 500 сая ам.долларын гадаад өр төлсөн, өнгөрсөн жилийнх шиг шинэ бонд олон улсын зах дээр арилжаалаагүй зэрэг нь урсгалд дарамт болсон. Оюу толгойн хөрөнгө оруулалт, алтны экспорт, олон улсын санхүүгийн байгууллага, доноруудын дэмжлэг валютын орох урсгалд ихээхэн дэмжлэг болж эдийн засагт санхүүжилтийн дутагдлыг нөхөхөд эерэгээр нөлөөлж байна.

Цар тахлын үед хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын арга хэмжээ юунд чиглэж байна вэ?

Цар тахлын сорилтын үед макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгын төлөө мөнгөний бодлогыг боловсруулан хэрэгжүүлж байна. Мөнгөний бодлогын нөлөөг илүү үр дүнтэй байлгахын тулд санхүүгийн зохицуулалт, макро зохистой бодлоготой хавсран хэрэгжүүллээ.

Хэвийн үед Мөнгөний бодлогын хороо хагас жилд хуваарийн дагуу хоёр хуралддаг бол энэ жил ээлжит болон ээлжит бусаар 4 удаа хуралдаж мөнгөний бодлогын болон макро зохистой бодлогын хүрээнд шийдвэрүүдийг гаргасан. Эдгээр шийдвэрүүд нь бүхэлдээ эдийн засгийн уналтыг сааруулах, сэргэх боломжийг хадгалахын тулд банкны, өрхийн болон аж ахуйн нэгжийн төлбөрийн чадвар, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжихэд чиглэж байна.

Гол арга хэмжээнүүдийг дурьдвал?

Тухайлбал, бодлогын хүүг хоёр удаа дараалан бууруулж 9 хувь болгож хадгаламжийн хүүнээс бага түвшинд хүргэсэн тул банкууд зээл олголтоо нэмэгдүүлэх, ялангуяа сайн зээлдэгчдэд илүү бага хүүгээр зээл гаргах санхүүгийн хөшүүргийг бий болгож байна. Мөн Заавал байлгах нөөцийн хувийг бууруулж төгрөгийн эх үүсвэрийг чөлөөлсөн нь банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дээшлүүлж, зээл гаргах эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зээл-хадгаламжийн хүүний зөрүүг бууруулах нөлөөтэй. Нөгөө талаас банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор зохистой харьцааны журмын түр өөрчлөлтүүдийг хийлээ. Мөн хүүний коридорыг нарийсгаснаар Төв банкнаас олгох санхүүжилтийн хүүг гурван нэгж хувиар бууруулсан байна. Түүнчлэн, Төв банкнаас олгох барьцаат зээлийн нөхцөлүүдийг эдийн засаг, санхүүгийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан илүү уян хатан болголоо. Өөрөөр хэлбэл, төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа нэмэгдүүлэх шаардлагатай тохиолдолд банкууд илүү хямд хүүгээр Төв банкнаас санхүүжилт авах бололцоог бүрдүүллээ.

Цаашид Монголбанкнаас ямар арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэх вэ?

Мөнгөний бодлогын хороо 9 дүгээр сарын 14-ний өдөр хуралдана. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл 9-р сарын 8-нд хуралдана. Эдгээр хурлуудаар бодлогын нэлээдгүй асуудлууд яригдана.

■ ■ ■
ТҮҮНЧЛЭН МОНГОЛБАНК 10-Р САРЫН 1-НЭЭС
ӨМНӨ ИРЭХ ЖИЛИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙГ УИХ-Д
ӨРГӨН БАРИХ ГЭХ МЭТ ТОМООХОН АЖЛУУД
ХИЙГДЭЖ БАЙНА.

Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх хэрэгслүүдийн хувьд, цаашид эдийн засгийн нөхцөл байдал болон санхүүгийн зах зээл дээр учирч болзошгүй эрсдэл, гадаад орчны тааламжгүй нөхцөл байдал дунд санхүүжилтийн шаардлагуудыг харгалзан илүү уян хатан болгох шаардлага үүсч болзошгүй байна.

Стратегийн хувьд, эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн төлөв, төсвийн бодлого, валютын урсгал, өрийн дахин санхүүжилт, зээлжих зэрэглэл зэрэг гадаад болон дотоод хүчин зүйлсийг харгалзан үзэж бодлогын шийдвэрүүдээ холбогдох хороодуудаараа гаргаад явна.

Сүүлд хуралдсан Мөнгөний бодлогын хорооны ээлжит бус хурлын шийдвэрийн үр нөлөө ямар байв?

Тус хурлаар хэрэглээний зээлийн хугацааг сунгах үйл ажиллагааны хэрэгжих хугацааг энэ оныг дуустал үргэлжлүүлэх шийдвэрийг гаргасан. 2020 оны эхний хагаст Ковид-19 цар тахлын сөрөг нөлөө иргэдийн орлогод мэдрэгдэж, нийт зээлийн багцын 25%-ийг бүрдүүлж байгаа хэрэглээний зээлийн эргэн төлөлтөд зарим хүндрэл учирч эхэлсэн. Иймд Монголбанкнаас банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дэмжих, зээлдэгчийн санхүүгийн дарамтыг зөөлрүүлэх зорилгоор хэрэглээний зээлийн бүтцэд өөрчлөлт оруулах боломжийг банкуудад олгосон. Ковид-19 цар тахлын нөлөөнд өртсөн хэрэглээний зээлүүдийн 15 хувьд нь бүтцийн өөрчлөлт хийгдээгүй байна. Дээрх хугацаа 7-р сарын 31-нээр дуусгавар болж байсныг он дуустал үргэлжлүүлэх шаардлагатай гэж үзээд Мөнгөний бодлогын хороо шийдвэрээ гаргасан. Түүнчлэн ипотекийн зээл болон бусад бизнесийн зээлүүдэд бүтцийн өөрчлөлт хийх боломжийг мөн Монголбанкнаас олгож байгаа.

Зээлийн төлбөр хойшлуулах, хугацаа сунгах эдгээр арга хэмжээний зорилго юу вэ?

Нэгд, зээлдэгчийн зээлийн төлбөрийн хэмжээг бууруулж байгаа нь санхүүгийн эрсдэлээсээ хамааран дампуурах эрсдэлийг бууруулж байна. Хоёрдугаарт, зээлийн чанарын ангилал хийн зээлийн мэдээллийн санд бүртгэхгүй байгаа нь тухайн зээлдэгчийн цаашид зээл авах үнэлгээг бууруулахгүй байх, зээл авах бололцоог хадгална. Ингэснээр эдийн засгийн сэргэлтийг түргэвчлүүлэхэд дэмжлэг болно. Түүнчлэн, хэрэглэгчийн орлогыг зээлийн төлбөрт суутгахын оронд гар дээр нь үлдээж байгаа нь хүндрэлийн үед хэрэглээг нь



хадгалах, макро агуулгаараа банкуудын болгоомжлол нэмэгдэж байгаа үед эдийн засагт эргэлдэж буй мөнгийг хумихгүй байх ач холбогдолтой.

Эдгээр шийдвэрүүдийн үр дүн ямар байсан бэ?

Өмнө дурьдсанчлан, шийдвэрүүд гол нь зээлдэгчийн хувьд үүссэн санхүүгийн эрсдэл, дарамтыг бууруулах зорилготой. Хэрэглээний болон ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулж, хугацааг сунгах хүрээнд нийт 100 мянга орчим зээлдэгчийн 2.8 орчим их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийсэн байна. Бизнесийн зээлүүдийн хувьд ч мөн адил бүтцийн өөрчлөлтүүд хийгдсэн.

СҮҮЛИЙН ХАНДЛАГААС ХАРАХАД САНХҮҮГИЙН ХУВЬД ИЛҮҮ ЭМЗЭГ ЗЭЭЛДЭГЧИД АВСАН ЗЭЭЛДЭЭ БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ ХИЙСЭН ХАРАГДАЖ БАЙНА. ТУХАЙЛБАЛ, 4-5 ДУГААР САРУУДАД 7 ХОНОГТ ДУНДЖААР 9000 ОРЧИМ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРЖ БАЙСАН БОЛ ЭНЭ ТОО 6 ДУГААР САРД 3307, 7 ДУГААР САРД 1807 БОЛЖ БУУРЛАА. ИРГЭДИЙН ЗЭЭЛЭЭС ГАДНА БИЗНЕСИЙН ЗЭЭЛҮҮД ДЭЭР 4 БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ ХИЙГДСЭН БӨГӨӨД НИЙТ 3.6 ИХ НАЯД ТӨГРӨГИЙН ААН-ИЙН ЗЭЭЛ ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨНД АВТСАН БОЛ ҮҮНЭЭС 7-Р САРЫН ЭХНИЙ БАЙДЛААР 1.5 ИХ НАЯД ОРЧИМД НЬ БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ ХИЙГДСЭН БАЙСАН.


Зээлийн бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ 2020 он дуустал үргэлжлэхээр Монголбанкны холбогдох шийдвэрүүд гарсан байгаа.

–Ярилцсанд баярлалаа!



ТӨГРӨГИЙН НАСЖИЛТ

(2017-2018 оны судалгаа)



Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гарснаас хойш устгалд орох хүртэлх дундаж хугацаа бүх дэвсгэртийн хувьд 3.8 жил байна.

Монголбанкнаас гүйлгээнд гаргасан 1, 5-тын дэвсгэртийн ердөө 0.3 хувь нь тооллогод эргэж ирдэг нь ихэвчлэн зориулалтын бусаар ашиглагдаж буйг илтгэж байна.

"ХАЛААСАНД БУС ХЭТЭВЧИНД, ОВООНД БУС ХЭРЭГЛЭЭНД" АЯН

2020.08.01-2020.10.01



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС

2020.08.19

Монголбанкнаас цаг үеийн асуудлаар хэвлэлийн бага хурлыг 2020.08.19-ний өдөр зохион байгуулж, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн сэтгүүлчдийн асуултад хариуллаа.

Аудитын газрын орлогч дарга байнгын хорооны хуралдааны үеэр хоёр том банкны үйл ажиллагаанд доголдол гарсан мэтээр мэдээлэл өгсөн нь шуугиан тарилаа. Энэ талаар Монголбанкнаас ямар байр суурь илэрхийлэх вэ?

- Эдийн засгийн байнгын хорооны хурлаар Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэлэлцэх явцад Үндэсний аудитын газрын төлөөлөл ташаа мэдээлэл өгсөн байна. Банк нь санхүүгийн зуучлагчийн үйл ажиллагаа явуулдагийн хувьд аливаа мэдээлэлд маш эмзэг байдаг. Банк нь нийгэм эдийн засагт ямар өндөр үүрэгтэй чухал салбар болохыг энд хэдхэн тоогоор илэрхийлье. Одоогийн байдлаар нийт банкны секторт эргэлдэж байгаа мөнгөний хэмжээ 35 орчим их наяд төгрөгт хүрээд байна. Эндээс зээлийн санхүүжилтэд 17 их наяд төгрөгийг иргэд аж ахуйн нэгж байгууллагад, нэмээд ипотекийн зээлийг оруулбал 20 гаруй их наяд

төгрөг болж байна. Өөрөөр хэлбэл, ийм их хэмжээний мөнгөн урсгалыг эдийн засагт, эргэлдүүлж байдаг салбар юм. Тэгэхээр иймэрхүү мэдээллээс үүдэн салбар доргих магадлалтай учраас Монголбанк албан ёсоор бодит нөхцөл байдлыг мэдэгдэж, байр сууриа илэрхийлэх ёстой.

Үндэсний аудитын газрын төлөөлөл мэдээлэл өгөхдөө хоёр том банк эрсдэлтэй байгаа гэсэн утгатай зүйл ярьжээ. Угтаа бол банкны системийн нөлөө бүхий болон жижиг гэж хоёр ялгадаг. Системийн нөлөө бүхий 5 банк байдаг. Хаан, Голомт, Хас, Худалдаа хөгжлийн банк, Төрийн банк. Бусад нь жижиг банк. 5 том банк нь банкны системийн нийт активын 85 хувийг бүрдүүлдэг. Үлдсэн 15 хувийг жижиг банкууд эзэлдэг гэсэн үг. Санхүүгийн салбар үндсэндээ банкны салбар дээр тогтож байна. Нийт санхүүгийн салбарын эх үүсвэр, санхүүжилтийн 90 хувийг банкууд

гаргадаг. Би сая банкны салбарт 35 их наяд төгрөгийн актив хөрөнгө байна гэж хэлсэн. Улсын төсөвтэй харьцуулахад, 3.5 дахин том дүн юм. Ийм том салбараас Монгол Улсын эдийн засаг санхүүжилт авч, тэжээгдэж, бизнесийн үйл ажиллагаа ч өрнөсөөр ирсэн. Санхүүгийн салбар тогтвортой, чадавхтай байж эдийн засаг тэр хэмжээгээрээ өсөж, тэлдэг. Монголбанк хуулийн хүрээнд банкны хяналт, шалгалтыг хийж байна. Манай улсын банкны салбарын үйл ажиллагаа тогтвортой, хэвийн байна. Тэр дундаа системийн нөлөө бүхий 5 том банкны бүх зохистой харьцааны үзүүлэлт хангагдаад явж байгаа.

ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд банкуудын активын чанарт үнэлгээ хийсэн. Мөн өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлага тавьсан. Энэ шаардлагыг банкууд биелүүлж дууссан уу. Уг асуудалтай холбоотойгоор зарим нэг банкны үйл ажиллагаа доголдсон гэх "явган" мэдээлэл гараад байгаа шүү дээ?

- Та бүхэн мэдэж байгаа, 2017 оны наймдугаар сард ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд активын чанарын үнэлгээ буюу банкны салбарт оношлогоо хийсэн. 2018 оны тавдугаар сард гарсан дүнгээр тухайн үед байсан 14 банканд 500-гаад тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгө нэмэгдүүлэх шаардлага байна гэсэн дүгнэлт гарсан. Гэхдээ энэ нь 7 банканд хамааралтай байсан асуудал. Монголбанкны зүгээс тодорхой хугацаа өгч, банкууд ч өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх эх үүсвэрийг олж ирсэн. Өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж буй үйл ажиллагаанд нь АНУ-ын компани магадлан шалгах аудит хийсэн. Энэ бүх үйл ажиллагаа одоо ч үргэлжлээд явж байна.

Өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлагатай байсан 7 банкнаас нэг нь буюу "Капитал" банк шаардлагыг биелүүлж чадаагүй. Тиймээс 2019 оны дөрөвдүгээр сард татан буугдсан. Татан буугдсан банканд дээр нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын сангийн 230 гаруй тэрбум төгрөг байршиж байсан. Энэ мөнгийг гаргаж авахад Монголбанкны Эрх хүлээн авагч ажиллаж байна. Гэтэл Үндэсний аудитын газраас үүнтэй холбоотой мэдээлэл хийхдээ

алдаа гаргажээ гэж Монголбанк үзэж байна. Өнөөдрийн байдлаар нийт 5 том банканд нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын сангийн 900 тэрбум төгрөгийн хөрөнгө байршиж байна. Үүнд ямар ч төлбөр тооцоо саатсан зүйлгүй, банкууд нь хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа учраас нөхцөл байдал хэвийн байна гэж хэлэхийг хүсч байна.

Одоогийн байдлаар хоёр том, хоёр жижиг банк өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Хоёр том банкны хувьд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх хөрөнгийн эх үүсвэрээ босгочихсон. Монголбанкны зохицуулалтын журмаар хоёрдугаар зэргийн өөрийн хөрөнгийг нь бүртгэчихсэн. Одоо үүнийг нэгдүгээр зэргийн өөрийн хөрөнгө рүү шилжүүлэх зохицуулалтыг хийх боломжтой. Гагцхүү магадлан нягтлах аудитын дүгнэлтийг хүлээгээд сууж байна. Ковидтой холбоотойгоор аудит нь хийгдэхгүй хойшилж байна. Гэхдээ өөрийн хөрөнгө нь ороод ирчихсэн байгаа. Өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэхээр ажиллаж байгаа хоёр жижиг банк бий. Эдгээр нь Үндэсний хөрөнгө оруулалтын банк болон "Чингис хаан" банк юм. ОУВС-тай хамтран хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хүрээнд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэхэд 2015 оны Эдийн засгийн ил, тод байдлыг хангах тухай хуулийн хүрээнд орж ирсэн эх үүсвэрийг оруулахгүй байх нь зүйтэй гэж зөвлөсөн. Дээрх хоёр банкны өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэхээр оруулж ирсэн эх үүсвэрийн ихэнх нь ил, тодын хуультай холбоотой учраас Монголбанк үүнийг өнөөдрийг хүртэл зөвшөөрөхгүй байгаа юм.

Зарим хүмүүс жагсаал хийж, зээлийн хүүг 3 хувь болгож бууруулахыг шаардаад байгаа. Монголбанкнаас зээлийн хүүг бууруулах чиглэлээр ямар бодлого барьж ажиллаж байна вэ?

- Монголбанкны зүгээс зээлийн хүүг бууруулах талаар стратеги боловсруулахад УИХ-ын гишүүдтэй хамтран ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар банкны салбараас олгож байгаа зээлийн жигнэсэн дундаж хүү 16.3 хувь байна. Энэ нь сүүлийн 4 жилд зээлийн хүү 4 нэгжээр буурсан үзүүлэлт юм. 2016 онд

зээлийн хүүний дундаж 20.6 хувьтай байсан. Сүүлийн 30 жилийн статистиктай харьцуулахад өнгөрсөн 4 жилд зээлийн хүү маш сайн буурсан. Бидний хамтран боловсруулж байгаа стратегид энэ эрчээ алдагдуулахгүйгээр 3-4 жилийн хугацаанд 4 нэгж хувиар буулгахаар зорьж байна. Яг одоогоор нөхцөл байдал тийм таатай биш байгаа хэдий ч, Монголбанк зорилтоо биелүүлэх боломжтой гэж харж байна. Тэгэхээр гудамжинд жагсаад, зээлийн хүүг 3 хувь болго гэж байгаа хүмүүсийн хувьд олон нийтийг өөртөө татах гэсэн, популизм л сонсогдоод байгаа юм. Тодорхой хэлбэл, нийт банкны системийн зээлийн хэмжээ 17 их наяд байна. 17 их наяд гэдэг нь улсын төсвөөс 170 хувиар их гэсэн үг.

Ийм их хэмжээний эх үүсвэрийг банкны систем олгож байна. Гэтэл банкны системд эргэлдэж байгаа мөнгөний 10 хувь нь эзнийх, 90 хувь нь олон нийтийнх буюу иргэд, аж ахуйн нэгжийн хуримтлал шүү дээ. Энэ мөнгийг банк зуучлаад, эдийн засаг руу гаргаж байхад мөнгийг нь үнэгүйдүүлж зээлийн хүүг 3 хувь болго гэж шаардана гэдэг нь нэгэнд нь сайн хандаад нөгөөг нь хохироох оролдлого хийх гэж байгаагаас огт ялгаагүй. Гэтэл төрийн аливаа шийдвэр нь тэгш хүртээмжтэй байх ёстой шүү дээ. Инфляци, валютын ханшийн өөрчлөлт, төлбөрийн тэнцлийн асуудлыг цогцоор нь шийдээгүй үед 3 хувь гэдэг бол үндэслэлтэй тоо биш. Хэрвээ банканд итгээд мөнгөө хадгалуулсан иргэдийн хуримтлалыг үнэгүйдүүлэх гэж байгаа бол банкны сектор цаашид яаж хэвийн үйл ажиллагаа явуулах вэ. Хэрвээ банкны сектор байхгүй бол Монгол Улс хэнээсээ зээл авч, эдийн засаг хэрхэн өргөжих вэ гэдэг асуултууд гарч ирнэ. Тиймээс зээлийн хүүг 3 хувь болго гэж яриад байгаа хүмүүсийн шаардлага ямар ч үндэслэлгүй, тооцоололгүй байна.

Өнөөдөр Монгол Улсад 12 арилжааны банк ажиллаж байгаа. Үүн дотор нэг л төрийн өмчтэй банк бий, үлдсэн нь хувийн сектор. Тэгэхээр санхүүгийн салбар тогтворгүй болж, хувийн банкуудын үйл ажиллагааг гацааж, доголдуулж болохгүй. Бүх улсад л банкны

сектор нь эдийн засгийн гол санхүүжилтийг хийдэг. Монголд ч бас ийм л жишгээр явж байгаа. Энэ тогтолцоог сүйтгэе гэж байгаа бол бид эргээд 30 жилээр ухарч, 30 жилийн өмнө байсан нэг банкнаас хамааралтай буюу улсын банкны тогтолцоо руугаа шилжсэнтэй ялгаагүй. Тэгэхээр 3 хувь гэж яриад байгаа хүмүүсийг хатуухан хэлэхэд, бидний өнөөдрийг хүртэл бий болгосон тогтолцоог сүйтгэх гэж байгаа, хорлон сүйтгэх гэсэн оролдлого гэж хэлэх байна.

Коронавирустэй холбоотойгоор эдийн засаг хүндэрч болзошгүй нөхцөл байдалд байгааг эдийн засагчид хэлж байна. Хагас жилийн байдлаар статистик үзүүлэлтүүд гарсан байх. Манай улсын эдийн засгийн нөхцөл байдал ямар байна вэ?

► Ковид-19 цар тахлын нөхцөл байдал тодорхойгүй байгаа хэдий ч макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын төлөө Монголбанк ажилласаар байна. Хагас жилийн статистик, эдийн засгийн гол гол үзүүлэлтийн тоонуудаас авч үзэхэд инфляц 7 дугаар сарын эцсээр 3.2 хувьтай байна. Энэ нь Монголбанкны зорилтод түвшин дотроо байна гэсэн үг. Үндсэндээ энэ тоо бол эдийн засаг макро түвшиндээ тогтвортой байгааг илэрхийлж байгаа хэрэг юм. Төгрөгийн ханш оны эхнээс 4.2 хувиар суларсан. Ялангуяа гадаад худалдаа, харилцаа төвөгтэй байгаа үед ханш маш тогтвортой байна гэж Монголбанкны зүгээс харж байна. Учир нь уул уурхайн бүтээгдэхүүн дээр экспорт нь суурилдаг манайх шиг эдийн засагтай улсуудад Коронавирусийн нөлөө маш хүнд тусаж байгаа.

Норвеги Улс гэхэд дэлхийн хамгийн баян улс. 1 их наяд ам.долларын баялгийн сангийн нөөцтэй. Гэтэл тэр улсын валютын ханш 17 хувиар суларсан. Тэгэхэд манай улс хангалттай их нөөцийг хуримтлуулж чадаагүй ч гэсэн өнөөдөр эдийн засгийн тогтвортой байдал хадгалагдаад, төгрөг маань ам.долларын эсрэг 4.2 хувиар суларсан явж байна. Манай улсын

валютын нөөц 3.6 тэрбум ам.доллар байна. Өнгөрсөн оны эцэст 4.3 тэрбум ам.доллар байсан. Бид өнгөрсөн хагас жилийн хугацаанд томоохон төлбөрүүдийг ч төлсөн. Засгийн газрын баталгаатай Худалдаа хөгжлийн банкны 500 сая ам.долларын төлбөрийг тавдугаар сард хийсэн.

Оны эхнээс хойш Төв банк ханшийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэхээр дуудлага худалдааг 7 хоногт хоёр удаа хийгээд явж байна. Тэр хүрээнд Монголбанк 1.2 тэрбум ам.долларыг нийлүүлсэн. Гэсэн хэдий ч манай нөөц 3.6 тэрбум ам.доллар буюу импортын 9 сарын хэрэгцээг хангахуйц хэмжээнд бий. Мөн ирэх оны тавдугаар сар хүртэл төлөх томоохон өр төлбөр байхгүй. 2021 оны тавдугаар сард “Мазаалай” бондын 500 сая ам.долларын төлбөрийг хийнэ. Энэ онд Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлцлийн хугацаа дуусч, дахин гурван жилээр сунгасан. Энэ нь бараг 2 тэрбум ам.долларын төлбөрийн асуудал байсан. Үүнийг сунгасан учраас одоо ийм хэмжээний дарамт байхгүй. Тэгэхээр ойрын хугацаанд ханш болон нөөц дээр томоохон дарамт байхгүй. Энэ үүднээс бид макро эдийн засгийнхаа тогтвортой байдлыг хадгалаад явж байгаа учраас зээлийн хүүг бууруулах боломж байна гэж үзэж байгаа.

Тэгвэл зээлийн хүүг бууруулахад яг ямар арга хэмжээ авах вэ?

- Зээлийн хүүг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө нь нэлээд нарийн тооцоо, судалгаанд үндэслэсэн. Тухайлбал, өнөөдөр тогтоод буй зээлийн хүүний бүтэц дээр авч үзвэл, хүүний зардлын дийлэнх буюу 60 хувийг нь эх үүсвэрийн зардал эзэлж байгаа бол 17 орчим хувь нь банкны өөрийн үйл ажиллагааны зардал, 11 хувь нь зээлийн эрсдэлтэй холбоотой зардал, үлдсэн хувь нь банкуудын хоорондын өрсөлдөөн, төвлөрлөөс үүдэлтэй зардлаас бүрдэж байна. Тэгэхээр эдгээр зардлаас ямар байдлаар яаж бууруулах арга хэмжээг авснаар зээлийн хүүг бууруулах вэ гэсэн тооцоо, судалгааг хийсэн. Эдгээр

судалгаа, шинжилгээнд сууриллилан цогц арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Ингээд ирэх 3-4 жилийн хугацаанд зээлийн хүүг дахин 3-4 нэгж хувиар бууруулах боломжтой гэж үзэж байгаа.

ОУВС-ийн хөтөлбөр хэрэгжиж дууссан. Гэвч хөтөлбөрийн хүрээнд банкны секторт хийгдэх ёстой байсан зарим ажлууд хэрэгжиж амжсангүй. Энэ асуудал цаашдаа хэрхэн шийдэгдэх вэ. Банкуудын өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн эх үүсвэрийг шалгах явцад хууль эрх зүйн дүгнэлт шаардлагатай болж, гацсан гэдгийг та хэллээ. Тэгэхээр цаашдаа энэ асуудлыг хэрхэн эцэслэн шийдвэрлэхээр ажиллаж байна вэ?

- ОУВС-ийн хөтөлбөр энэ оны 5 дугаар сард дууссан. Хөтөлбөр дуусч байгаа боловч, хөтөлбөрөөр хийгдэх ёстой ажлууд хийгдэхгүйгээр үлдвэл яах вэ гэдэг асуудал бий. Монгол Улсын хувьд банкны салбар маань тогтвортой, эрүүл, чадавхтай байх ёстой. Монгол Улсын банкны салбарын чадавхтай байх нь Төв банкны үүрэг учраас бид хөтөлбөртэй, хөтөлбөргүй үүргээ хүлээн ажилласаар л байх болно. Тийм ч учраас бид банкны салбарыг дунд хугацаанд чадавхжуулах хөтөлбөр боловсруулан УИХ-д хүргүүлээд байна. УИХ-ын өмнөх хаврын чуулганаар, эдийн засгийн байнгын хорооноос энэ хөтөлбөрийг хэрэгжүүл гэсэн тогтоол гаргасан.

Активын чанарын үнэлгээний хувьд банкуудын татсан эх үүсвэр дээр форенсик аудит хийгдсэн. Үүний дагуу тодорхой асуудлуудад хууль эрх зүйн дүгнэлт хэрэгтэй гээд уг асуудал гацсан. Хорио цээрийн дэглэмтэй байгаа учраас бид АНУ-ын “Дафф энд Фелипс” гэдэг компанийг дахин Монгол Улсад авчирч чадахгүй. Тиймээс Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа дэлхийд нэр нь танигдсан томоохон аудитын компаниудын хүрээнд форенсик аудитыг үргэлжүүлж болно гэж үзэж байгаа. Гэхдээ банк өөрөө санаачлаад, үүн шиг аудит хийлгэж болно гэдэг зөвшөөрлийг өгсөн. Гагцхүү хорио цээрийн дэглэмтэй холбоотойгоор бүх зүйл хойшлоод байна.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ


2020 оны 07 дугаар сарын статистик мэдээллийн тойм

1. Мөнгөний үзүүлэлт

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (эх үүсвэр талаас)




Зураг 1.2 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (байршуулалт талаас)



- Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өсч 21.5 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 8.2 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 1.7 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 0.1 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, -1.7 нэгж хувийг төгрөгийн харилцах, -2.5 нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлж байна.
- M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 18.4 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 3.1 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна.

2. Зээл

Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор



Зураг 2.2. Зээл, зээлийн чанар




- Нийт зээл 17.2 их наяд төгрөг (төгрөгийн зээл 15.6 их наяд, гадаад валютын зээл 1.6 их наяд төгрөг)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.3%-иар
- Хэвийн зээл өмнөх сараас 1.4%-иар тус тус буурч,
- Чанаргүй зээл өмнөх сараас 24.6 тэрбум,
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас 128.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

3. Ипотекийн зээл

Зураг 3.1. Тайлант сард олгосон ипотекийн зээл




Зураг 3.2. Ипотекийн зээл чанарын ангиллаар




- Тайлант сард банкууд 1,077 зээлдэгчид 74.8 тэрбум ₮-ийн ипотекийн зээл шинээр олгосноос 57.3% нь хөтөлбөрийн, 42.7% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.
- Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурч, өмнөх сараас 0.2 нэгж хувиар өсч 10.7 хувьд хүрсэн байна.

4. Хүү

Зураг 4.1. Нийт шинээр татсан хадгаламжийн хүү



Зураг 4.2. Нийт шинээр олгосон зээлийн хүү




- 2020 оны 7 дугаар сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) **10.5** хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ **3.2** хувь байна. Гадаад валютын ЖДХ өмнөх оны мөн үеэс **1.6** нэгж хувиар буурчээ.
- Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ **15.8** хувь, гадаад валютын зээлийн ЖДХ **10.6** хувь болж, шинээр олгосон төгрөгийн зээл өмнөх оны мөн үеэс **1.4** нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.


*Хотолборийн тээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.

4. Хүү

Зураг 4.3. Зээлийн хүү, секторын ангилал




Зураг 4.4. Зээлийн хүү, салбарын ангилал





*Хотолборийн тээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.

5.1. Гадаад өрийн статистик, 2020 оны II улирал



	2020.I	2020.II	Өөрчлөлт
Засгийн газар	7,236	7,891	▲ 655
Зээл	4,748	5,139	▲ 391
Бонд, өрийн бичиг	2,488	2,753	▲ 265



Өөрчлөлт	Сая \$
(275) ▼	
372 ▲	
655 ▲	
(510) ▼	
110 ▲	

ХАЛХ ЭХНЭРИЙН АЛТ ШАРМАЛ, ПААЛАН ГҮЙЛГЭСЭН ТАВАН САВААГҮЙ



ХХ ЗУУН
30.8 X 7.2 CM
АЛТ ШАРМАЛ МӨНГӨ, ПААЛАН, ШҮР ОЮУ

ЭНЭХҮҮ БЭЛНИЙ ЭРГҮҮЛГИЙГ УТСАН СҮЛЖМЭЛ ХЭЭГЭЭР ЧИМЭГЛЭН ШҮР, ОЮУ ШИГТГЭСЭН БӨГӨӨД АЛТ ШАРМАЛ ХЭРЭГСЭЛ НЬ ЦЭЦЭГ НАВЧИН ХЭЭТЭЙ. ХАРИН ҮНЭРТЭН БОЛОН АЛЧУУР ЗҮҮХ ХЭРЭГСЛИЙГ ӨНГИЙН ПААЛАН ГҮЙЛГЭН ЧИМЭГЛЭСЭН БАЙНА.
ХАЛХ ЭХНЭР ХҮН ТАШААНДАА НЭГЭН ТӨРЛИЙН БЭЛ ЧИМЭГ БҮЮУ ТАВАН САВААГҮЙ ЗҮҮХ БӨГӨӨД БЭЛ НЬ ЭРГҮҮЛЭГТЭЙ БАЙНА. ЭРГҮҮЛГЭНЭЭС ХЭЛНИЙ ХУСУУР ҮНЭРТНИЙ САВ, ХУМС ЦЭВЭРЛЭГЧ, ЧИМХҮҮР БОЛОН АЛЧУУР УЯХ ХЭРЭГСЭЛ ЗЭРГИЙГ ЗҮҮЖ ХЭРЭГЛЭНЭ.



**НООЛУУРЫН ТОГТВОРТОЙ
НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭГ НОГООН
САНХҮҮЖИЛТИЙН МЕХАНИЗМ АШИГЛАН
ЗӨВ АЖИЛЛУУЛАХ НЬ**

Монгол Улсын Санхүүгийн Тогтвортой Байдлын Зөвлөлөөс 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Ногоон таксономийг баталсан билээ. Ингэснээр Монгол Улс нь Европын Холбооны дараагаар үндэсний Ногоон таксономи баталсан 2 дахь улс болсон бөгөөд Дэлхийн Банкны Ногоон таксономи боловсруулах заавар, гарын авлагад сайн туршлагын нэгээр дурдагдсан. Монгол Улсын Ногоон таксономи нь 8 салбарын 58 үйл ажиллагааг ногоон үйл ажиллагаа хэмээн тодорхойлсон.

Энэ удаагийн дугаарт Ногоон таксономийн 7 дахь ангилал буюу “Тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлал” гэсэн ангиллын Тогтвортой нэхмэлийн боловсруулалт ба үйлдвэрлэл гэх дэд ангиллыг онцолж байна.

НОГООН ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ 7 | **ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**

Аливаа улс орны нэхмэлийн салбар нь тухайн орны онцлогоос хамааран нийт хүлэмжийн хийн ялгарлын 2-10 хувийг үүсгэдэг бөгөөд тус салбарын үйлдвэрлэл, хөгжил цаашид энэ хэвээр үргэлжилбэл 2050 он гэхэд энэ салбар дангаараа дэлхийн нийт нүүрсхүчлийн хийн ялгарлын дөрөвний нэгийг бүрдүүлдэг болно гэсэн тооцоолол байна. Иймд сүүлийн жилүүдэд дэлхий нийтийн хандлага өөрчлөгдөж, түүхий эд бэлтгэлээс эхлээд үйлдвэрлэл, боловсруулалт, борлуулалтын шат дамжлага бүрийг байгальд хор хөнөөл багатайгаар шийдвэрлэх, эрчим хүч, усны хэмнэлттэй техник технологи нэвтрүүлэх, хүн байгальд сөрөг нөлөөгүй химийн бодис ашиглах, салбарын хүний нөөцийн чадавх, аюулгүй ажиллагаа, хүний эрхийн асуудлууд,

мөн засаглалын асуудлыг ихээхэн анхаардаг болж байна. Нэхмэлийн салбар, тэр дундаа ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь ДНБ-д оруулах хувь нэмрээрээ уул уурхайн салбарын дараа ордгийн хувьд стратегийн ач холбогдолтой салбар юм. Монгол Улсын хэмжээнд ноос, ноолуур боловсруулах салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бүртгэлтэй нийт 300 орчим үйлдвэр байгаагаас иж бүрэн цогцолбор үйлдвэр 15, анхан шатны боловсруулах үйлдвэр 23, сүлжмэлийн ЖДҮ 59, өрхийн жижиг цех 150-200 байна. Тус салбарт 10,000 гаруй ажилчид ажиллаж, тэдгээрийн дийлэнх буюу 85 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж, нийт ажиллах хүчний 60 хувийг залуучууд эзэлж байна. Монгол Улс нь дэлхийн ноолуурын нөөцийн 40 орчим хувийг бүрдүүлдэг бөгөөд тус салбарын борлуулалтын орлогын 86 хувийг экспортын орлого, үлдсэн 14 хувийг дотоодын хэрэглэгчид бүрдүүлдэг.¹ Монголчууд бид эрт дээр үеэс мал сүрэг, бэлчээр усаа дээдэлж, хайрлан хамгаалсаар ирсэн ч сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт хурдацтай явагдаж, хүн төрөлхтний байгальтайгаа харьцах зөв сайхан уламжлалт зан үйл мартагдахын хэрээр бэлчээрийн талхагдал, цөлжилт, малын эрүүл мэнд, тавлаг байдлын тухай асуудал, ямааны ноолуурын гарц болон чанарын асуудал ихээхэн хөндөгдөх болоод байна. Түүнээс гадна ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн дамжлагын үеэрх хаягдал ус, химийн бодис, томоохон үйлдвэрүүдийн эрчим хүчний их хэрэглээ зэрэг нь хүлэмжийн хийг бусад салбараас өндрөөр ялгаруулж, байгаль орчинд тодорхой хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлдэг. Орчин цагийн хэрэглэгчид уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны асуудлууд, хүний эрх, жендер гэх мэт нийгмийн асуудлуудад онцгой ач холбогдол өгч сонголт хийдэг, бүтээгдэхүүн нийлүүлэгчдэд өндөр шаардлага тавьдаг болсны ачаар ихэнх хөгжингүй орнуудад, ялангуяа Европын орнуудад тогтвортой үйлдвэрлэлийн стандарт ихээхэн хэвшээд байна. Харин байгаль орчинд үзүүлэх байдал, мөн бүтээгдэхүүн нь өөрөө өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, түүнчлэн эдийн засгийн чухал ач холбогдолтой салбар зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр энэ салбарыг төрөөс тусгай

анхааралдаа авч ажиллах шаардлага мөн байна.

ТОГТВОРТОЙ НЭХМЭЛИЙН САЛБАР НЬ УЛАМЖЛАЛТ НЭХМЭЛИЙН САЛБАРААС ЯЛГАРАХ НЬ

Тогтвортой гэдэг үгийн цаана байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэгш байдлыг хангах тухай агуулга багтдаг болохыг бид мэднэ. Тогтвортой байдал, тогтвортой хөгжлийн тухай асуудал 1970-аад оноос хойш яригдаж эхлэн, их бага хэмжээгээр янз бүрийн хөгжлийн түвшинд улс орнууд, салбарууд “тогтвортой” болох руу шилжиж байна. НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөрийн санаачилгаар Монголын тогтвортой ноолуурын платформ (МТНП) үүсгэн байгуулагдаж тогтвортой нэхмэлийн салбарын чухал оролцогч талуудыг хамруулсан платформын удирдах хороо болон техникийн ажлын хэсгүүдийг байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд бүхий л оролцогч талуудын санал бодлыг тусгаж, нэгтгэн тогтвортой нэхмэлийн салбарын тодорхойлолтыг гаргасан юм.

“Монголын тогтвортой ноос, ноолуурын салбар гэдэг нь зүй зохистой бэлчээрийн мал аж ахуйг эрхлэх, байгаль орчны нөлөөг бууруулах, үр өгөөж болон үүрэг хариуцлагыг зөв хуваарилах замаар нэмүү өртгийн сүлжээний дасан зохицох ба сэргэх чадамжийг хангахад чиглэсэн, мөшгөх боломжтой, хэмжигдэхүйц, ил тод, тасралтгүй, ёс зүйтэй үйл ажиллагаа юм.”²

Дээрх тодорхойлолтод байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлуудыг харгалзан үзсэн нь харагдаж байгаа хэдий ч, эдгээрийг ямар хүчин зүйлүүд бүрдүүлэх нь бас нэгэн чухал асуудал юм. МТНП-ийн ажлын хэсгийн гишүүдийн зүгээс тогтвортой нэхмэлийн салбарын тодорхойлолт дахь бүрэлдэхүүнийг дараах байдлаар тодорхойлоод байна.

¹ Монголын нэхмэлийн салбарын ЖДҮ-үүдийн ногоон санхүүгийн зах зээлийн эрэлтийн судалгаа, Гэрэгэ Партнерс ба ToC Холбоо, 2019 он.

² Монголын Тогтвортой Ноолуурын Платформын “Тогтвортой ноолуурын зөвшилцөл” ажлын хэсгийн хэлэлцүүлгээс гаргасан тодорхойлолт.

Байгаль орчин, ач холбогдлоор жигнэсэн



Эх сурвалж: Монголын Тогтвортой Ноолуурын Платформын “Тогтвортой ноолуурын зөвшилцөл” ажлын хэсгийн хэлэлцүүлгээс гаргасан тодорхойлолт

Нийгэм, ач холбогдлоор жигнэсэн



Эх сурвалж: Монголын Тогтвортой Ноолуурын Платформын “Тогтвортой ноолуурын зөвшилцөл” ажлын хэсгийн хэлэлцүүлгээс гаргасан тодорхойлолт

Эдийн засаг, ач холбогдлоор жигнэсэн



Эх сурвалж: Монголын Тогтвортой Ноолуурын Платформын “Тогтвортой ноолуурын зөвшилцөл” ажлын хэсгийн хэлэлцүүлгээс гаргасан тодорхойлолт



Дүрслэл 1: Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний зураглал, ТоС Холбоо

ТОГТВОРТОЙ НООС, НООЛУУР ГЭХЭЭР ЯАГААД ЗӨВХӨН НООС, НООЛУУРЫН ҮЙЛДВЭРҮҮДИЙГ БИШ НООЛУУРЫН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭГ ЦОГЦООР НЬ АВЧ ҮЗЭХ ЁСТОЙ ВЭ?

Таны худалдан авч буй ноолууран цамцыг бүтээх явцад ямааны тавлаг байдлыг алдагдуулж, бэлчээрийг доройтуулж, хүүхдийг албадан хөдөлмөрлүүлж, эсвэл уг цамцыг урлаж буй үйлдвэр эрэгтэй, эмэгтэй ажилтнууддаа эрс ялгаатай цалин өгсөн, хаягдал ус болон бусад төрлийн хатуу хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулсан бол таны цамц тогтвортой, байгаль орчинд ээлтэй ноолууран цамц байж чадахгүй юм. Ийм учраас бэлчээрээс авхауулаад мал маллагаа, малчин өрх, боловсруулалт, тээвэрлэлт гээд нийлүүлэлтийн сүлжээний бүхий л үе шатуудыг авч үзэж байж тогтвортой ноолуур гэдэг ойлголтыг бий болгох юм.

ТЭГВЭЛ НОГООН САНХҮҮЖИЛТ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭЖ ЧАДАХ УУ?

Хөрөнгө оруулагч тал буюу санхүүжүүлэгч талын шийдвэр үргэлж хүчтэй нөлөөтэй байдаг учраас хөрөнгө оруулагчийн зүгээс тавигдах шаардлагуудад шинээр байгаль орчин, нийгэм, засаглалтай холбоотой шаардлагуудыг нэмж оруулах замаар тогтвортой хөгжлийг бий болгож болох юм гэж зорьсны үндсэн дээр тогтвортой санхүүжилтийн санаачилга өрнөж эхэлсэн түүхтэй. Энэ жишгээр нэхмэлийн салбарыг илүү тогтвортой, илүү сайн засаглалтай, илүү байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулахад санхүүжүүлэгч талын оролцоо тун өндөр юм. Хэдийгээр байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөө бүхий бизнесүүдийг санхүүжүүлэхгүй байх нь тэдний сөрөг үйл

ажиллагааг дэмжихгүй, цааш газар авхуулахгүй байхад нөлөөтэй боловч нөгөө талаас эсрэгээрээ эдгээр бохирдол ба хүлэмжийн хий ихээр ялгаруулагч салбаруудыг ногоон санхүүжилтээр хангаж, тэдэнд үйл ажиллагаагаа байгаль, нийгэмд ээлтэй явуулах шаардлага, шалгууруудыг тавьж өгснөөр тэдгээр салбаруудыг ногооруулах боломжтой юм. 2019 онд хийгдсэн Монголын нэхмэлийн салбар дахь ногоон санхүүжилтийн зах зээлийн эрэлтийн судалгаанаас харахад нийт нэхмэлийн салбарын ЖДҮ-ийн ногоон санхүүгийн эрэлт бодит төсөөллөөр 250 тэрбум төгрөг, зорилтот төсөөллөөр 576 орчим тэрбум төгрөг байгаа бол нөгөө талаас Монголын нэхмэлийн салбарын аж ахуйн нэгжүүд авах боломжтой ногоон санхүүжилтийн боломжит нийт эх үүсвэр 75 тэрбум төгрөг байна гэсэн дүгнэлт гарсан. Гэвч боломжит 75 тэрбум төгрөгийн ногоон санхүүжилтийн эх үүсвэрээс ердөө нэг ААН 150 сая төгрөгийн зээл авсан тухай мөн судалгаанд дурджээ. Үүнээс нэхмэлийн салбарын ногоон санхүүжилтийн эрэлт ба нийлүүлэлт хоорондоо нийцэхгүй байгаа нь тод харагдаж байгаа ба нэг талаас банк, санхүүгийн байгууллагууд боломжит ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, эх үүсвэрээ хэрэгцээтэй зах зээлдээ хүргэж чадахгүй байна, нөгөө талаас нэхмэлийн салбарын ААН-үүд хүний нөөц, хөрөнгө санхүүгийн болон мэдээллийн дутмаг байдлаас хамааран боломжит эх үүсвэрүүд рүү хандаж, шаардлагатай санхүүжилтээ авч чадахгүй байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.



Эх сурвалж: Монголын нэхмэлийн салбарын ЖДҮ-үүдийн ногоон санхүүгийн зах зээлийн эрэлтийн судалгаа

Уг судалгааны үр дүнг харгалзан үзсэний үндсэн дээр Монголын Тогтвортой Санхүүгийн Холбооноос нэхмэлийн салбарын тогтвортой санхүүжилтийн удирдамж³, нэхмэлийн салбарын байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн

үнэлгээний аргачлал, нэхмэлийн салбар дахь ногоон зээлийн шалгуур, банк санхүүгийн салбарын ажилтнуудад зориулсан тогтвортой нэхмэлийн салбарт зээл олгох тухай гарын авлага зэргийг боловсруулаад байна. Эдгээр баримт бичгүүд нь банк, санхүүгийн салбарын ажилтнуудын хувьд нэхмэлийн салбарын талаар зөв ойлголттой болох, энэ салбарын эрсдэлийг зөв үнэлэх, боломжуудыг олж харахад тустай бол нэхмэлийн салбарын үйлдвэрүүдийн хувьд санхүүжүүлэгч байгууллагын ногоон шалгуурыг хангахад өөрийн үйл ажиллагаа, баримт бичгийг нийцүүлэн бэлдэхэд дөхөм болох юм.

Цаашид Ногоон таксономийн бусад салбаруудад дээрх шиг тусгайлсан зөвлөмж, эрсдэлийн үнэлгээний аргачлал, ногоон санхүүжилтийн зах зээлийн эрэлтийн судалгаа, тухайн салбарт зориулсан ногоон зээлийн шалгууруудыг боловсруулах шаардлагатай бөгөөд ингэснээр ногоон зээл олголтыг нэмэгдүүлж, Ногоон хөгжлийн бодлогын зорилтуудыг хангахад нэг алхам ойртох юм. 2020 оны 2-р улирлын байдлаар Ногоон таксономийн ангилал 7 буюу “Тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлал” чиглэлд хамгийн их ногоон зээлийн үлдэгдэлтэй, мөн хамгийн их шинээр олгосон зээлтэй байна.



Эх сурвалж: Монголбанкны ногоон зээлийн статистик тайлан, 2020 оны 2-р улирал



Эх сурвалж: Монголбанкны ногоон зээлийн статистик тайлан, 2020 оны 2-р улирал

3 (<http://toc.mn/post/111>)

МОНГОЛБАНКНЫ ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ МЕТАЛЛ 5 ТОННООР ӨСӨВ

Монголбанк 2020 оны 8 дугаар сард 1.7 тн үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр нийт 14.8 тн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5.0 тн-р өссөн үзүүлэлт юм. Монголбанкны нийт худалдан авсан 14.8 тн үнэт металлын 13.1 тн нь алт, 1.7 тн нь цагаан мөнгө байна.

Тайлант сард Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 87.8 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 209.7 кг үнэт металл худалдан аваад байна. Он гарснаас хойш орон нутаг дахь Монголбанкны 2 хэлтэс нийт 1.1 тн үнэт металл худалдан авлаа. Монголбанкны тайлант сард худалдан авсан 1 грамм алтны дундаж үнэ 180,096.17 төгрөг байв.


Дүрслэл 1. 2018-2020 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын сарын мэдээ (кг)



Дүрслэл 2. 2020 оны 8 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг/грамм)




Дүрслэл 3. 1990-2020 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын хэмжээ (тонн)



ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлсэнээс хойш 2020/08/31-ний хооронд 2,901.7 сая ам.долларын болон 113.4 сая юанийн нийт 1692 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



МОНГОЛБАНКНЫ ОНБМТ-ИЙН ЗАХИРАЛ
Б.ОДОНТУНГАЛАГТАЙ МӨНГӨН ТЭМДЭГТИЙН
СОЁЛТОЙ ХЭРЭГЛЭЭГ ХЭВШҮҮЛЭХЭД
МОНГОЛБАНКНААС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ЯРИЛЦЛАА.



МӨНГӨН ТЭМДЭГТИЙН СОЁЛТОЙ ХЭРЭГЛЭЭ НЬ ОЛОН ТАЛЫН АЧ ХОЛБОГДОЛТОЙ

Монголбанкнаас “Халаасанд бус хэтэвчинд, овоонд бус хэрэглээнд” аяныг хэрэгжүүлж эхэлжээ. Энэ аяны хүрээнд ямар үйл ажиллагааг идэвхтэй өрнүүлж байна вэ?

Юуны өмнө хэлэхэд, Монголбанк бол үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг хэвлүүлэх, гүйлгээнд гаргах, гүйлгээнээс татах онцгой эрхтэй төдийгүй төгрөгийн нөөц, аюулгүй байдлыг хангаж ажилладаг. Энэ онцгой эрхийнхээ хүрээнд төгрөгийн хүчин төгөлдөр эсхийг тодорхойлох, гэмтэж муудсаныг солих, устгах ажлыг эрхлэн гүйцэтгэдэг. Энэ үүргийнхээ хүрээнд хийж буй ажлуудын нэг нь “Халаасанд бус хэтэвчинд, овоонд бус хэрэглээнд” аяныг хэрэгжүүлж байна. Энэ хугацаанд олон нийтийн дунд мөнгөн тэмдэгтийг зүй зохистой гамтай хэрэглэх, хэрэглээний соёлд хэвшүүлэх, мөнгөн дэвсгэрттэй зохистой харьцахад чиглэсэн сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг таниулах ажлыг зохион байгуулж байна. Учир нь Монгол Улсын гүйлгээнд эргэлдэж байгаа мөнгөн тэмдэгт нь хэрэглэгчдийн буруу хадгалалт, соёлгүй

хэрэглээнээс шалтгаалан муудаж хүчингүй болох явдал улам бүр нэмэгдсээр байна. Мөн үндэсний мөнгөн тэмдэгтийг хил гаалиар зөвшөөрөлгүй гаргах, шашны зан үйлд хэрэглэх явдал түгээмэл байна. Эндээс үзэхэд иргэдэд мөнгөн тэмдэгт нь улс үндэстний тусгаар тогтнолын билэгдэл, үнэт цаасных нь хувьд хэрхэн зүй зохистой хандах талаар уриалж, мэдлэг мэдээллээр хангах нэн шаардлагатай байна. Аяныг наймдугаар сараас аравдугаар сар хүртэл хэрэгжүүлэх юм.

Уг аяныг хэр өргөн хүрээг хамруулан зохион байгуулж байна вэ?

Монголбанкны орон нутгийн салбар, хэлтэс болон зарим төрийн байгууллагууд, арилжааны банкуудтай хамтран улс орон даяар хэрэгжүүлж байна. Аяны хүрээнд дээр дурдсан үйл ажиллагаануудыг зохион байгуулахаас гадна олон нийтэд сүсэг бишрэлийн хэт туйлширсан байдлыг залруулж ойлгуулах ажлыг мөн зохион байгуулж байна. Энэ нь юу вэ гэхээр мөнгөн дэвсгэртийг уул, овоо, түүхэн дурсгалт

газруудад өргөх хандлага газар авч байгаа нь анхаарал хандуулах асуудал болж байна. Учир нь мөнгөн тэмдэгт зориулалтынхаа хувьд зөвхөн төлбөр тооцоонд хэрэглэгдэх ёстой атал шашин шүтлэгийн зориулалтаар эзгүй орхигдож байгаа нь зохимжгүй юм.

ЭНЭ НЬ ЭДИЙН ЗАСАГТАА Ч БАЙГАЛЬ ОРЧИНДОО Ч СӨРӨГ ҮР ДАГАВАРТАЙ БОЛОХЫГ АЯНЫХАА ЯВЦАД ОЙЛГУУЛЖ, ЭНЭ БАЙДЛЫГ ДАХИН ДАВТАГДАХГҮЙ БАЙХАД ЗОРЬЖ БАЙГАА ЮМ. ТИЙМЭЭС УУЛ, ОВООНД ӨРГӨСӨН МӨНГӨН ДЭВСГЭРТҮҮДИЙГ ЦУГЛУУЛАХ ХӨДӨЛГӨӨН ОРОН ДАЯАР ӨРНҮҮЛЖ, ЦУГЛУУЛСАН МӨНГӨӨРӨӨ САЙН ҮЙЛСИЙН АЯН ХИЙХЭЭР АЖИЛЛАЖ БАЙНА. ҮҮНЭЭС ГАДНА МӨНГӨТЭЙ ЗҮЙ ЗОХИСТОЙ ХАРЬЦАХАД ХЭВШҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАС НЭГ АСУУДАЛ НЬ ТҮРИЙВЧНИЙ СОЁЛЫГ ТҮГЭЭХ ЮМ. МӨН МӨНГӨН ТЭМДЭГТЭЙ ЗӨВ ХАРЬЦАХ, ЭНЭ НЬ МӨНГӨН ТЭМДЭГТИЙГ ҮНДЭСНИЙ ТУСГААР ТОГТНОЛЫН БАТАЛГАА БОЛОХЫНХ НЬ ХУВЬД ДЭЭР НЬ БИЧИЖ, ЗУРАХГҮЙ, ЖИЖИГЛЭН НУГАЛЖ ЭВХЭХГҮЙ БАЙХ ГЭХ МЭТЭЭР ЗОХИСГҮЙ БАЙДЛААР ХАНДАХГҮЙ БАЙХЫГ ЗӨВЛӨХ, ҮҮНИЙ ЗЭРЭГЦЭЭ ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛД ЗОРИУЛЖ МӨНГӨӨ ЗӨВ УДИРДАХ ТУХАЙ ТАНИУЛАН СУРТАЛЧЛАХ ОЛОН ХЭЛБЭР БҮХИЙ МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ, ЗӨВЛӨМЖ ЗӨВЛӨГӨӨГ ТҮГЭЭЖ БАЙНА.

Төгрөгийн насжилт 3.8 жил байгаа нь бусад улс орны мөнгөн тэмдэгттэй харьцуулахад хангалтгүй гэж байна. Тэгэхээр олон улсын жишигт мөнгөн тэмдэгтийн насжилт хэдэн жил байна вэ?

Мөнгөн тэмдэгтийн насжилт 3.8 жил гэсэн тоо бол дундаж үзүүлэлт юм. Том дүнтэй дэвсгэртүүд үүнээс илүү насжилттай, зарим жижиг дэвсгэртүүд 3.8 жилээс ч богино наслах тохиолдол бий. Өөрөөр хэлбэл, мөнгөн тэмдэгтийн насжилт дунджаар 1-5 жилийн хооронд хэлбэлзэж байдаг. Энэ үзүүлэлт цаашид нэмэгдэх эсвэл багасах нь нэг талаас олон нийтийн мөнгөн тэмдэгттэй харьцах соёлоос хамаарч байдаг. Олон улсын

жишгээс харахад Австрали улсад бага дүнтэй дэвсгэртүүд 5 хүртэлх жил, том дэвсгэртүүд нь 20 гаруй жил гүйлгээнд эргэлддэг гэдэг. Тэгвэл АНУ-ын долларын дундаж насжилт 9.9 жил байдаг гэсэн судалгаа бий. Төгрөгтэй харьцуулбал даруй 2.6 дахин урт насжилттай байна. Цаашлаад ам.долларын хувьд гүйлгээнд идэвхтэй ашиглагддаг ам.долларын 5-тын дэвсгэрттийн насжилт 4.7 жил, 100 ам.долларынх 22.9 жил байна. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн том, жижиг дэвсгэрттэй харьцах хандлага ялгаатай байдгаас насжилтын хувьд ч мөн харилцан адилгүй байдал үүсдэг нь олон улсын жишээн дээрээс харагддаг. Үүнд хэрэглээний соёл их нөлөө үзүүлдэг гэдгийг давхар хэлэх хэрэгтэй.


Мөнгөн тэмдэгтийг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах гээд бүхий л шатанд зардал их гардаг гэдэг. Гэтэл ингэж зардал гаргаж хэвлэсэн мөнгө хэтэрхий хурдан элэгдэхээр улсын эдийн засагт ч сөрөг нөлөөтэй байх. Энэ талаар мэдээлэл өгнө үү?

Зардалтай холбоотой гол асуудал нь мөнгөн тэмдэгтийн зохистой хэрэглээтэй холбогддог. Нэгдүгээрт, иргэд мөнгийг нугалах, базах, урж тастах, юм бичих зэргээр зохисгүй харьцсанаас болж гүйлгээн дэх хуучирсан, хиртсэн, урагдсан, хамгаалалтын элемент нь арилсан гэх мэт дахин ашиглах боломжгүй, муу мөнгөн дэвсгэрттийн тоо хэмжээ улам л ихэссээр байгаа.

Эдгээр мөнгөн дэвсгэртүүдийг устгахаас өөр аргагүй болдог. Хоёрдугаарт, сүсэг бишрэлийн зорилгоор газарт булсан, суварга босгоход хийсэн, уул овоонд өргөсөн жижиг дэвсгэртүүд зах зээлд эргэлдэхгүй түгжигдэж байна гэсэн үг юм. Тэгэхээр мөнгөн тэмдэгтийг зориулалтын бусаар ашиглах, зохисгүй харьцсанаас үүдэн дахин хэвлүүлэх шаардлага гарч зардал ч нэмэгддэг. Мөнгөн дэвсгэрт бүтэх үйл явцаас эхлээд устгахад хүртэл зардал гардаг гэдэг нь маш ойлгомжтой тул үндэсний мөнгөн тэмдэгтээ соёлтой хэрэглэж хэвших шаардлагатай байна.

Ярилцсанд баярлалаа.

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН БАНКНЫ СЕКТОРТ БИЙ БОЛГОЖ БАЙГАА ӨӨРЧЛӨЛТ



Бид өмнөх дугаарууддаа Ковид-19 цар тахлын үед улс орнуудын зүгээс бодлогын түвшинд ямар арга хэмжээг авч хэрэгжүүлж байгааг мэдээлж байсан билээ. Тэгвэл энэ удаад Ковид-19 нь банкны салбар, түүний үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг 2 үндсэн сэдвийн хүрээнд хүргэхийг зорилгоо.


ХЯМРАЛЫГ ДАВАХ ХҮЧ

Та бид Олон Улсын санхүүгийн хямрал (2008-2009) банкны системийн шокоос үүдэлтэй гэдгийг мэднэ. Ер нь өнгөрсөн 50 орчим жилийн хугацаанд дэлхийн эдийн засагт тохиосон томоохон хямралууд нь голцуу санхүүгийн зах зээлийн асуудлаас үүдэлтэй байж иржээ. Харин 2020 онд гарсаар үүсээд байгаа хүндрэл нь тэс өөр шалтгаантай бөгөөд банкны сектор нь хамгийн чухал дэмжих хүч болоод байна. Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд улс орнууд банкны секторын эрсдэл даах чадвар, аливаа нөхцөлд санхүүгийн зуучлалыг тасалдуулахгүй байх чадавхийг бүрдүүлсэн нь өнөөдөр бодит эдийн засагт, иргэд, аж ахуйн нэгжид нэн шаардлагатай байгаа зээлийг олгож, төрөөс өгч байгаа санхүүжилтийг үр ашигтай дамжуулах дэд бүтэц болж байна.

Гэхдээ цаашид энэ байдал хэр удаан үргэлжлэх вэ гэдэг нь Ковид-19 цар тахлыг хэдий хугацаанд хяналтдаа оруулах вэ гэдгээс гадна банкны эрсдэл даах чадвар буюу эрүүл мэнд хэдий хугацаанд хадгалагдах вэ гэдгээс хамаарна. Цар тахал, түүнээс үүдэлтэй хорио тавигдсанаас хойш зээлийн эргэн төлөлтөд өөрчлөлт орж энэ секторын алдагдлын хэмжээ өссөн. Зээлээ хэвийн төлөх чадамжтай нэгэн байхад хэвийн үед зээл аваад цар тахлаас үүдэлтэй үйл ажиллагаа нь хүндэрсэн байгууллага, иргэд нь зээлийн хугацааг хэтрүүлэх, чанаргүй зээлдэгч болох тохиолдол өсч

байна. Банк нь иргэдийн мөнгийг авч хадгалж, зохих журмын дагуу тодорхой хэсгийг нь зээл болгож гаргадаг. Чанаргүй зээлийн хэмжээ өсч байна гэдэг нь эрсдэлийн сангийн зардал нэмэгдэж, өөрийн хөрөнгө буурна гэсэн үг. McKinsey & Company-ийн зүгээс АНУ, Европын эдийн засаг өмнөх түвшиндээ 2021-2023 онд хүрэхгүй бол банкуудын 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө 100-400 тэрбум ам.доллараар буурах төсөөлөл гаргажээ.

Сайн мэдээ бол АНУ, Европын банкууд өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, эрсдэлд мэдрэг байдлаа багагүй хэмжээгээр бууруулсан. Тухайлбал, 2019 оны байдлаар Европын холбооны банкуудын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа нь 13%, Их Британид 14%, АНУ-д 12% байжээ. Хэрэв нөхцөл байдал дордохгүй ч, эдийн засгууд төдийлөн өмнөх түвшиндээ сэргэж амжихгүй (дүрслэл 1 – A1, A2, B2 график) гэж үзвэл Европт энэ харьцаа 8.5-10.0 хувьд, Их Британид 11-13 хувьд, АНУ-д 8.0-10.5 хувьд хүрч буурах тооцоо хийсэн байна. Мэдээж зарим банкуудын үзүүлэлт муудаж хүндэрч болох ч, системийн хэмжээнд эрсдэл бага гэсэн үг. Хамгийн гол нь эдийн засгийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөх вэ гэдгээс бүх зүйл хамаарна. McKinsey & Company- аас гаргасан төсөөллийг дараах дүрслэлээс үзнэ үү.



Дүрслэл 1: Дэлхийн эдийн засгийн өсөлтийн хувилбарууд (эх сурвалж: McKinsey & Company)

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИННОВАЦИ

Эрнст & Янг аудитын компаниас өнгөрсөн сард хийсэн судалгаанд нийт оролцогчдын 43 хувь нь Ковид-19 цар тахлын улмаас банкаар үйлчлүүлэх харилцаанд өөрчлөлт орсон гэж хариулжээ. Мэдээж хорио тогтоосон үед банкаар үйлчлүүлэх хүн тийм ч их байхгүй л болов уу. Тус судалгаанд оролцогчдын 3-ны 2 нь банкаар биечлэн үйлчлүүлэхээ багасгасан гэж байгаа. Нөгөө талаас хорионы үед 50 орчим улсын 250 банкууд ч салбаруудаа түр хаасан. Үүний үр дүнд цахим банкны үйл ажиллагаа огцом идэвхжиж, банкууд ч энэ чиглэлээр маш их хөгжүүлэлт, сайруулалтыг хийж байна. Өнөө үед дийлэнх үйлчилгээ цахимаар шийдэгдэх боломжтой болсон энэ үед банкны үйлчилгээнд хийгдэж байсан дижитал өөрчлөлтийн хурд огцом нэмэгжээ.


Судалгааны өөр нэг асуултанд нийт оролцогчдын 24 хувь нь 12-24 сарын хугацаанд цахим банкны үйлчилгээнд бүрэн итгэхээ хэлсэн бол 16 орчим хувь Ковид-19 цар тахлын дэгдэлт намжих үед банкны хэвийн үйлчилгээнд шилжинэ гэжээ. Аль ч тохиолдолд банкны үйлчилгээнд ихээхэн өөрчлөлт гарч байгаа ба харилцагчдын багагүй хэсэг нь үүнд итгэлтэй байгаа аж. Хэрэв банкууд өөрсдийн зах зээлд эзлэх байр сууриа хадгалъя, үйл ажиллагааны зардлаа буруулъя гэж бодож байгаа бол банкны сектор дахь дижитал инновацид нэгдэх хэрэгтэй юм. Үүн дээр мөн маркетингийн шинэ арга хэлбэрүүд ч

нэмэгдэх боломжтой. Мэдээж юм болгонд эрсдэл байдагтай адил цахим төлбөр тооцонд ч асуудал гарч байгаа. Энэ нь мэдээллийн аюулгүй байдал, цахим луйвар юм. Банкны зүгээс үүнийг хамгийн бага түвшинд хязгаарлахаар бүх арга хэмжээг авч байгаа ч иргэдийн зүгээс үүн дээр анхаарах шаардлагатай байна. Тухайлбал цахим банкны нууц үгээ хадгалах, үйлчилгээний газруудын интернет сүлжээгээр нэвтрэхдээ болгоомжтой байх, банкнаас ирж байгаа мэдээлэл, сануулгатай танилцаж байх нь зүйтэй. Монголбанкнаас ч энэ чиглэлээр бусад байгууллагуудтай хамтран "Ятгах тусам нягтал", "Нягтлах тусам аюулгүй" аянуудыг хэрэгжүүлээд байгаа.

Түүнчлэн цахим төлбөр тооцоо нэмэгдсэнээр бэлэн мөнгөний хэрэглээ огцом буурчээ. Жишээ нь, Эрнст & Янгийн судалгаанд оролцогчдын 57% нь бэлэн мөнгөний хэрэглээгээ бууруулсан гэж байгаа ба 7% нь кредит карт, 10% нь дебит карт, 14% нь цахим төлбөр тооцоонд шилжсэн гэжээ. Мөн дэлгүүрээс биечлэн хүнсээ авч байгаа хүмүүсийн 34% нь контактлесс карт ашиглаж байгаа гэсэн байна. Ер нь иргэд олон нийт цахим төлбөр тооцоог сонгох байдал улам нэмэгдэж байгаа нь бэлэн мөнгөний хэрэглээ, түүнээс үүдэх зардлыг бууруулах ач холбогдолтой.

Эх сурвалж: McKinsey & Company, Banking system resilience in the time of COVID-19 Ernst & Young, COVID-19 is reshaping consumer banking behavior

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 2020 ОНЫ 8 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДРИЙН БАЙДЛААР)



2008 ОНЫ БЭЭЖИНГИЙН ОЛИМПОД ЗОРИУЛАН ГАРГАСАН ЗООС

НҮҮР ТАЛ: ЗООСНЫ ТӨВ ХЭСЭГТ 2008 ОНЫ БЭЭЖИНГИЙН ОЛИМПИЙН ТОГЛОЛТООС МЕДАЛЬ ХҮРТСЭН Н.ТҮВШИНБАЯР, Д.БААТАРЖАВ, О.ГҮНДЭГМАА, Э.БАДАР-УУГАН, П.СЭРДАМБА НАРЫН ХӨРГИЙГ ДҮРСЭЛЖ, ДЭЭД ТАЛААР НЬ "OLYMPIC GAMES 2008" ДООД ТАЛААР НЬ "MONGOLIAN COINS" ГЭЖ АНГЛИАР БИЧСЭН.

АР ТАЛ: МОНГОЛБАНКНЫ ЭМБЛЕМНИЙ ХОЁР ТАЛД "МОНГОЛ", "УЛС" ГЭЖ МОНГОЛ БИЧГЭЭР, ДООД ТАЛД Ы МӨНГӨН ТЭМДЭГТИЙН НЭРЛЭСЭН ҮНИЙГ КИРИЛЛ ҮСГЭЭР БИЧИЖ, УЛСЫН НЭР, ЖИН, СОРЬЦ, ТӨМӨРЛӨГ ЗЭРГИЙГ "MONGOLIA 1000G, 999 SILVER" ГЭЖ АНГЛИАР БИЧСЭН.



2008 ОНЫ БЭЭЖИНГИЙН
ОЛИМПОД ЗОРИУЛАН ГАРГАСАН
ЗООС

ОН: 2008
НЭРЛЭСЭН ҮНЭ: 20000 ТӨГРӨГ
МЕТАЛЛ: МӨНГӨ 999
ЖИН: 1000 ГР

**БНХАУ-ЫН АРДЫН БАНКНЫ
ТЭРГҮҮН ИЙ ГАНГ:**

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ, БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХЭД АНХААРАЛ ХАНДУУЛНА



Цар тахлаас үүдэлтэйгээр Хятадын Ардын Банк санхүүгийн ямар бодлогыг хэрэгжүүлж, хариу арга хэмжээ авч байна бэ?

Цар тахлын нөлөөнөөс үүдэж Хятадын Ардын Банк мөнгөний бодлогын мөчлөг сөрсөн зохицуулалтыг эрс нэмэгдүүлж, бодлогын шинэ арга хэрэгслийг нэвтрүүллээ. Авсан хамгийн гол арга хэмжээнүүдийг “нийт хэмжээг тэлэх, нийлүүлэлтийг нэмэх, өсөлтийг дэмжих, зээлийн хүүг бууруулах, бүтцийн тохируулга хийх, нийгмийн гол хэсгийг хамруулах” гэсэн үгээр илэрхийлж болох юм.

Он гарснаас хойш, Ковид-19 цар тахал нь дэлхий нийт болон БНХАУ-ын эдийн засагт урд тооцоолж байгаагүй шокиг бий болголоо. Хятадын Ардын банкны зүгээс мөчлөг сөрсөн мөнгө, санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, ажлын байрыг хадгалах, аж ахуйн нэгжүүдийг тогтворжуулах бодлогын шинэ арга хэрэгслүүдийг ашиглаж байгаа. Тиймээсэнэ сэдвийн хүрээнд Хятадын Ардын банкны тэргүүн Ий Гангийн Синхуа агентлагт өгсөн ярилцлагыг хүргэж байна.

Цагаан сарын үеэр бид яаралтай 300 тэрбум юанийн тусгай зээлийг гаргаж, нийлүүлэлт хийсэн нь эерэг үр дүнд хүрлээ. Цагаан сарын дараа буюу 2-р сарын 3-нд санхүүгийн зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангаж, богино хугацааны хөрвөх чадварыг 1.7 их наяд юаньд хүргэв. Энэ оны 1-р сарын 1-ний өдөр заавал байлгах нөөцийн харьцааг 0.5 хувиар бууруулах мэдэгдэл хийснээс хойш тухайн харьцааг хоёр удаа бууруулж, нийт 1.75 их наяд юанийн эх үүсвэрийг чөлөөлсөн.

Улмаар 300 тэрбум юань, 500 тэрбум юань, 1 их наяд юанийн дахин санхүүжилт, хөнгөлөлтийг тус тус олгосон. Нөхцөл байдлаас хамаарч бодлогын чиг хандлага өөрчлөгдөж, мөн зээлийн хүү улам бүр зах зээлийн зарчимд тулгуурладаг болж өөрчлөгдөж байна. Арилжааны банкууд Төв банкны эдгээр хэрэгсэл, санхүүжилтийг эдийн засагт хямд өртөгтэй зээл олгоход ашигладаг бөгөөд энэ нь аж ахуйн нэгжүүдийг тогтворжуулах, ажлын байрыг хадгалахад дэмжлэг үзүүлж байна.

Эхний хагас жилийн байдлаар санхүүгийн гүйцэтгэлийг хэрхэн үнэлж байна вэ?

Оны эхний хагаст санхүүгийн макро үзүүлэлтэд олон гэгээлэг өөрчлөлтүүд бий болсон ба энэ нь мөнгөний бодлогыг зохистой бөгөөд үр дүнтэй хэрэгжүүлж байгааг харуулж байна. Макро өнцгөөс харахад санхүүгийн үзүүлэлтүүд өнгөрсөн жилийнхээс хамаагүй ахисан байна. 6-р сарын эцэст мөнгөний нийлүүлэлт (M2) өмнөх оны мөн үеэс 11.1% -иар өссөн, нийгмийн санхүүжилтийн цар хүрээ өмнөх оны мөн үеэс 12.8% -иар өссөн, оны эхний хагасын байдлаар 12.1 их наяд юанийн шинэ зээл олгосон нь өмнөх оны мөн үеэс 2.4 их наяд юаниар өссөн үзүүлэлт юм.

Үнийн түвшний хувьд энэ жил бид хүүг зах зээлийн зарчмаар бууруулах чиглэл дээр анхаарч ажиллаж байна. Нээлттэй зах дээрх 7 хоногийн урвуу репог 30 суурь нэгжээр бууруулж 2.2%-д, дунд хугацааны санхүүжилтийн хүү 30 суурь нэгжээр бууруулж 2.95%-д, 1 жилийн хугацаатай зээлийн суурь хүүг (LPR) 30 нэгжээр бууруулж 3.85%-д хүргэснээр дахин санхүүжилтийн хүүг 50 суурь

нэгжээр буурууллаа.

Мөнгөний бодлогын үндсэн чиглэл нь нийт зах зээлийн хүүг буурахад нөлөөлж, аж ахуйн нэгжүүд санхүүжилтийн зардлаа багагүй хэмжээгээр багасгахад тусаллаа. 6-р сард репо бондын жигнэсэн дундаж хүү 1.89% болж, өмнөх оны эцсээс 0.21 хувиар буурчээ. 10 жилийн хугацаатай Засгийн газрын үнэт цаасны өгөөж 2.82% болж, өмнөх оны эцсээс 0.32 хувиар буурлаа. Мөн аж ахуйн нэгжүүд, тэр дундаа боловсруулах үйлдвэрүүдийн зээлийн хүү түүхэн доод түвшинд хүрч буураад байна. Тодруулбал, хүртээмжтэй санхүүжилтийн зээлийн хүү одоогоор 5 орчим хувьтай байгаа нь өнгөрсөн оноос 0.8 хувиар бага юм.

Хүүгийн бууралт нь бодит эдийн засгийг эрчтэй дэмжиж, зээлийн бүтцийг оновчтой болгов. Жижиг болон бичил бизнес эрхлэгчдэд зориулсан зээлээр санхүүжсэн зах зээлийн тоглогчид эрс нэмэгдлээ. 6-р сарын сүүлчийн байдлаар зээлтэй 30 орчим сая аж ахуйн нэгж зээлийн данстай байгаа ба 23 сая нь зээлийн үлдэгдэлтэй байна. Эдгээр нь ихэвчлэн жижиг, бичил үйлдвэрлэл эрхлэгчид, хувиараа үйлдвэрлэл болон худалдаа эрхэлдэг өрхүүд байгаа.

Хятадын өнөөгийн макро эдийн засгийн байдлыг хэрхэн дүгнэх вэ?

Коронавируст шинэ тахлыг БНХАУ үр дүнтэйгээр удирдлагадаа оруулснаар, манай улс дэлхийд эдийн засгаа сэргээж чадсан анхны орон болсон. Хоёрдугаар улиралд манай улсын ДНБ харьцангуй сайн сэргэсэн бөгөөд ДНБ өмнөх оны мөн үеэс 3.2% -иар өсч, эерэг өсөлттэй дэлхийн цорын ганц томоохон эдийн засаг болжээ.

Нэг талаас нь харвал хэд хэдэн салбар харьцангуй хурдан сэргэсэн ба нөгөө талаас эрэлт болон хэрэглээ аажмаар сэргэн, хөрөнгө оруулалт илт нэмэгдэж, экспорт сайжирсан. Эдийн засаг сэргэж байгаа энэ үед ч үнийн түвшин тогтвортой хэвээр байна.

Эдийн засгийн өнөөгийн сэргэлтэд нөлөөлж буй асуудлууд, тухайлбал аж ахуйн нэгжүүдийг тогтворжуулах, ажлын байрыг хадгалах,

жигжиг, дунд, бичил үйлдвэр эрхлэгчид болон үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг өрхүүдийн үйл ажиллагааг сэргээхэд тулгарч буй хүндрэлүүдийг бид давахад ихээхэн анхаарч байна.

Ерөнхийдөө Хятадын эдийн засгийн потенциал, хүндрэлийг даван туулах чадавх өөрчлөгдөөгүй байна. Энэ жилийн хоёрдугаар хагаст манай улсын эдийн засаг үргэлжлэн сэргэх бөгөөд жилийн турш эерэг өсөлттэй байх төлөвтэй байгаа.

Сурвалжлагч: Хятадын Ардын Банк 2020 оны хоёрдугаар хагаст юун дээр анхаарлаа төвлөрүүлэх вэ?

Ий Ганг: Оны хоёрдугаар хагаст Хятадын Ардын банк Намын Төв Хороо болон Улс төрийн товчооны шийдвэрийг хэрэгжүүлж, тогтвортой байдлыг хадгалахын зэрэгцээ ахиц дэвшил эрэлхийлэх хандлагыг хадгална. Хөгжлийн шинэ үзэл баримтлалыг дагаж мөрдөхийн зэрэгцээ, нийлүүлэлтийн талын бүтцийн шинэчлэлд анхаарлаа хандуулж, “зургаан чиглэлт тогтвортой байдлыг” тууштай хэрэгжүүлэх болно. Тэдгээр нь санхүүгийн салбарын үзүүлэлтүүд алгуур бөгөөд тогтвортой өсөх бололцоог бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг хангах, санхүүгийн томоохон эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх, санхүүгийн шинэчлэл болон нээлттэй байдлыг гүнзгийрүүлэх, эдийн засаг, санхүүгийн эрүүл хөгжлийг тэтгэх, тогтворжуулах асуудлуудад анхаарлаа хандуулах тухай юм.

Мөнгөний бодлого илүү уян хатан, оновчтой, нарийвчлалтай байх ёстой бөгөөд үүн дээр аж ахуйн нэгжүүдийг тогтворжуулах, ажлын байрыг хангах бодлогыг нэмж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Мөн мөнгөний нийлүүлэлт, нийгмийн санхүүжилтийн цар хүрээний өсөлтийн хурдыг өнгөрсөн жилийнхээс өндөр түвшинд байлгахад чиглэсэн мөнгөний бодлогын олон арга хэрэгслийг цогцоор нь ашиглаж, өөрчлөлтөд мэдрэг байх, бүтцийг оновчтой болгох, жигжиг, бичил бизнесийн зээлийн хүртээмжтэй өсөлтийг дэмжих ажилд давхар анхаарлаа хандуулах болно.



Санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх мөн шийдвэрлэх хүрээнд эрсдэлийг хамгийн доод түвшинд байлгаж, төлөвлөгөө ёсоор 3 жилийн турш хэрэгжүүлсэн ажлаа гүйцээх дээр бүх хүчээ дайчлан ажиллаж, санхүүгийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны дутагдлыг арилгах ажлыг түргэсгэх, санхүүгийн томоохон эрсдэл үүсэхэд онцгой байдлын хариу арга хэмжээ авах механизмыг боловсронгуй болгож, тогтмолжуулах хэрэгтэй. Нэгтгээд хэлэхэд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хянах, эрсдэлийг арилгах ажлууд юм.

Түүнчлэн, бид хөдөө орон нутгийн санхүүгийн байгууллагуудын санхүүгийн тогтолцоо, механизмын реформыг гүнзгийрүүлж, санхүүгийн шинэчлэлийн арга хэмжээний хэрэгжилтийг дэмжиж, бүс нутгийн санхүүгийн эрсдэлийг шийдвэрлэх чиглэлээр орон нутгийн засаг захиргаанд дэмжлэг үзүүлж, орон нутгийн санхүүгийн байгууллагуудын зах зээлийн зарчимд тулгуурласан шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд анхаарч байна.

Олон улсад төвөгтэй бөгөөд тогтворгүй байдал давамгайлж байгаа нь БНХАУ-ын санхүүгийн зах зээлийн нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, олон улсын хамтын ажиллагаа, юанийн олон улсын харилцаанд нөлөөлөх үү?

Олон улсын байдал хэрхэн өөрчлөгдөхөөс үл хамааран хамгийн чухал зүйл бол бид өөрсдийн хийх ёстой зүйлээ хийж, санхүүгийн салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлж, гадаад ертөнцөд нээлттэй байдлыг нэмэгдүүлэх явдал юм. Юуны өмнө бид БНХАУ, АНУ-ын эдийн засаг, худалдааны хэлэлцээрүүдийн эхний үе шатыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээс гадна сүүлийн жилүүдэд зарласан санхүүгийн шинэчлэл болон зах зээлийг нээлттэй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал, үнэт цаасны салбарт гадаадын хувьцааны хязгаарлалтыг арилгах, хөрөнгө оруулалтын сангийн удирдлага, фьючерс, хувийн даатгал, гадаадын мэргэшсэн хөрөнгө оруулагчдад болон тэдний хөрөнгө оруулалтын хэмжээнд тавигддаг хязгаарлалтыг цуцлах, БНХАУ-ын зах зээлд Express, MasterCard, Fitch гэх мэт байгууллагуудын ажиллах зөвшөөрлийг олгох гэх мэт ажлууд юм. Хоёрдугаарт, pre-entry national treatment буюу гадаадын хөрөнгө оруулагчдыг ижил түвшинд үзэж, сөрөг жагсаалтын менежментийн системд бүртгэгдээгүй этгээдүүдийн бүх хязгаарлалтыг арилгаж, бондын зах зээлд гадаад валютын удирдлагын нэгдсэн байдлыг хангаж, бусад улсад илүү нээлттэй болгоно.

БНХАУ нь цар тахлын эсрэг олон улсын хамтын ажиллагааг үргэлж дэмжсээр ирсэн. Бид үргэлжлүүлэн дэлхийн эдийн засаг, санхүүгийн засаглалд идэвхтэй оролцож, олон талт үзлийг хамгаалж, хөгжиж буй орнууд болон хөгжил буурай орнуудад дэмжлэг үзүүлэх буюу "Их 20"-ийн өрийг бууруулах санаачилгад бүтээлчээр оролцох болно.

Одоогийн байдлаар юань буюу ренминби (RMB)-г олон улсын болгох үйл явц сайн байгаа. Оны эхний хагаст RMB-ийн хил дамнасан орлого ба төлбөрийн хэмжээ 12.7 их наяд юаньд хүрч, өмнөх оны мөн үеэс 36.7%-аар өссөн байна. RMB нь найман жил дараалан хил дамнасан орлого болон төлбөрийн хоёр дахь том валют боллоо. Олон Улсын Валютын нөөцөд эзлэх хувь энэ оны 1-р улиралд 2%-иас давсан бөгөөд энэ нь 2016 онд ОУВС-ийн валютын сагсанд багтаж эхэлснээс хойш хоёр дахин өссөн үзүүлэлт юм. Бид юанийг олон улсын чанартай болгох, хөрөнгийн дансыг нээлттэй болгох ажлыг идэвхтэй бөгөөд тогтвортой үргэлжлүүлэн хийх болно.

Эх сурвалж: http://www.xinhuanet.com/fortune/2020-08/09/c_1126345276.html



ТӨВ БАНКНЫ ЗАСАГЛАЛ: ЕВРОПЫН ТӨВ БАНК БОЛОН ХБНГУ-ЫН ТӨВ БАНКНЫ ТУРШЛАГА

Д.ДАВААСАМБУУ /МУИС-ийн Олон улсын
харилцаа, нийтийн удирдлагын
сургуулийн ахлах багш.
Цахим шуудан: ddalrai@gmail.com/

өртөхгүй байх нөхцөлийг хангаж, түүнийгээ сахисаар иржээ. Өдгөө ХБНГУ-д Төв банкны гүйцэтгэх зөвлөлийн 6 гишүүнийг түүний дотор ерөнхийлөгчийг хуульд зааснаар 8 жилээр томилж тогтвортой ажиллуулдаг ажээ.

Төв банк бие даасан байх нь онолын үндэстэй ажээ. Тухайлбал, улс төрийн сэдэлтэй эдийн засгийн шийдвэр гарах эрсдэлтэй. Жишээлбэл, Засгийн газар (сонгогддог удирдлага) сонгуульд чиглэсэн тактикийн хүрээнд мөнгөний бодлогыг зүй бусаар ашиглаж чадна. Үүнээс хамгаалах эрх зүй чухал ажээ. ХБНГУ-ын Төв банк өөрийн хуулийн 19 дүгээр зүйлд заасан нөхцөлийг хангасан найдвартай бонд, вексель үнэт цаасыг худалдах, худалдан авах замаар мөнгөний зах зээлийг удирддаг бөгөөд, эдийн засагт мөнгө нийлүүлэх өөр арга замыг хязгаарласан хуультай ажээ.

Банкийг удирдахдаа бие даасан хамтын (Гүйцэтгэх удирдлагын гишүүд нь ерөнхийлөгчөөс хараат бусаар, гэхдээ нэгдмэл удирдлагатай, мэргэжлийн байхыг бодолцсон томилгооны журамтай) мэргэжлийн удирдлагын зарчмыг мөрддөг байна. Энэ зарчмыг ХБНГУ-ын Төв банк, Европын Төв банкинд адилхан хэрэгжүүлж байна. Энэхүү хамтын удирдлагыг Холбогдох Төв Банкуудын Гүйцэтгэх удирдлагын зөвлөл хэрэгжүүлж байна. ХБНГУ-ын Төв банк нь зургаан гишүүнээс бүрдсэн Гүйцэтгэх Удирдлагын Зөвлөлтэй байна. Тэднээс Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч нарын гурван гишүүнийг Засгийн газраас, нөгөө гурван гишүүнийг Парламентын дээд танхимаас

1. ЗАСАГЛАЛ БА АУДИТ

Дэлхий дахины туршлагаас үзэхэд Төв банк бие даасан байхын учир нь үнэ болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад төв банк улс төрөөс ангид, мэргэжлийн түвшинд бие даасан байдлаар ажиллаж, энэ зорилтыг хангадаг ажээ. Улс төрийн хамааралтай байснаас алдаа гаргасан гашуун туршлага түүхэнд олон байдаг. Жишээлбэл, Герман дэлхийн I ба II дайны үед Засгийн газрын шийдвэрээр асар их мөнгө гаргаж, 1923 онд гипер инфляцид орсон, 1948 онд мөнгөний реформ хийж байжээ. Ийм байдал дахин гараагүй бөгөөд төв банкны удирдлага сонгууль болон улс төрийн сэлгээ, өөрчлөлтөд



шалгаруулан Засгийн газартай зөвшилцөн нэр дэвшүүлж, ХБНГУ-ын Ерөнхийлөгчөөр томилуулдаг байна. Бундесбанкны Гүйцэтгэх удирдлагын зөвлөл хамтын шийдвэр гаргаж, хамтын хариуцлага хүлээдэг байна.

Европын Төв банк буюу ЕТБ-ны удирдах дээд байгууллага нь тус банкны Гүйцэтгэх зөвлөлийг бүрдүүлдэг. Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч болон бусад байнгын дөрвөн гишүүн, нийт зургаан гишүүн дээр Европын бүсийн орнуудыг төлөөлсөн 15 саналын эрхтэй Төв банкны ерөнхийлөгч (таван том орон нь нийлээд дөрвөн саналын эрхтэй, үлдсэн 16 орон нь 11 саналын эрхтэй, энэ хоёр бүлэг орнууд ээлжлэх журмаар саналын эрхээ хэрэгжүүлнэ) оролцсон Удирдах зөвлөл байдаг. ЕТБ-ны энэхүү Удирдах зөвлөл нь мөнгөний бодлого хийгээд банкны хөрөнгө, нөөц, ашиг хуваарилалтын талаар шийдвэр гаргана.

ЕТБ нь аливаа орны Төв банкттай адил эрх хэмжээ үүрэгтэйн дээр гишүүн орнуудынхаа Төв банкуудтай хамтран ажиллаж, заавар чиглэл өгдөг ажээ. ЕТБ-ны дээд болон гүйцэтгэх удирдлага, ажилтнууд гишүүн орнуудын иргэд бөгөөд тэнд харилцан нэг нэгэндээ хяналт тавьж ажиллах үндэстэй.

ЕТБ-ны Ерөнхий Зөвлөл гэж байдаг бөгөөд энэхүү зөвлөл нь ЕТБ-ны Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч болон Европын Холбооны гишүүн 27 орны төв

банкуудын ерөнхийлөгчдөөс бүрддэг. Энэхүү Ерөнхий Зөвлөл нь мөнгөний бодлогын уялдаа зохицуулалт, нэгдсэн статистик мэдээлэл, тайлан гаргах, ханш зэрэг асуудлыг хариуцдаг байна.

Хүснэгт 1 Дэлхийн зарим орнуудын үзүүлэлтүүд

Суурь жил: 2016	Евро-19 орнууд	Евро-28 орнууд	АНУ	Япон	БНХАУ
Нийт хүн ам (сая)	340.3	511.8	323.4	127	1,382
ДНБ (их наяд)	16.9	17.1	18.6	5.3	21.4
Нэг хүнд ногдох ДНБ (мянган ам.доллар)	36.7	42.5	44	36.1	13.4
Дэлхийн ДНБ-д эзлэх хувь	11.7	17.0	15.5	4.4	17.7
Экспорт (ДНБ-д эзлэх хувь)	27	17.4	11.9	16.4	21.3
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал (ДНБ-д эзлэх хувь)	19.7	20.0	19.9	24.0	45.0
Нийт хадгаламж (ДНБ-д эзлэх хувь)	23.0	22.0	18.8	27.2	48.0

2. ЕВРОПЫН БОЛОН ХБНГУ-ЫН МӨНГӨ, САНХҮҮГИЙН БҮТЭЦ БА МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Дэлхийд Европын холбооны эзлэх байр суурийг бусад зэрэгцээ оронтой харьцуулж үзүүлбэл:

ЕТБ болон ХБНГУ-ын Төв банкны үндсэн зорилт бол эргэлт буцалтгүй үнийн тогтвортой байдлыг хангах нэг нэгдсэн зорилттой гэж хуульчилсан хэдий ч эдийн засгийг дэмжинэ гэсэн хоёр дахь санаа хууль тогтоомжуудад байдгийг тайлбарласан. Үүнийг ЕТБ АНУ-ын Холбооны нөөцийн сантай харьцуулан танилцуулсан. Тухайлбал, Европын холбооны үйл ажиллагааны тухай гэрээний 127 дугаар заалтад "Төв банкуудын Европын тогтолцооны үндсэн зорилт нь үнийн тогтвортой байдлыг хангахад оршино. Үнийн тогтвортой байдлыг хэрэгжүүлэхэд хөндлөнгийн нөлөөлөлд автахгүй байх, Европын холбооны эдийн засгийн бодлогыг дэмжих, Европын холбооны үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх" гэж заажээ. Тэгвэл АНУ-ын Бүрэн ажилт эрхлэлт ба тэнцвэртэй өсөлтийн тухай 1976 оны хуульд "Мөнгөний болон зээлийн агрегат өсөлтийг эдийн засгийн үйлдвэрлэлийн

урт хугацааны нөөц бололцооны үндсэн дээр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгыг үр дүнтэйгээр үнийн тогтвортой байдлыг хангах, урт хугацаандаа зээлийн хүүг нам доор хэмжээнд барих бодлогыг хэрэгжүүлнэ” гэж заажээ. Үүнээс харахад АНУ-д мөнгөний бодлого, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, үнийг тогтвортой байлгах, зээлийн хүүг дунд хугацаанд зохих түвшинд байлгахыг зааж өгсөн нь харагдаж байна.

ХБНГУ-ын Төв банкны Гүйцэтгэх зөвлөл нь мөнгөний бодлогын асуудлаар нэгдсэн шийдвэрт хүрэхдээ эдийн засгийн газрын судалгаа, мөн мөнгөний газрын судалгаа хоёрын аль алиныг нь авч үзэж шийдвэрлэдэг байна. Энэхүү хоёр газрын судалгаа, дүгнэлт, төсөөллийг тус банкны ерөнхий эдийн засагч хариуцан зохицуулдаг байна.

Мөнгөний нэгдсэн бодлоготой бөгөөд харин хэрэгжилтийг нь төвлөрсөн бус буюу еврог хэрэглэдэг орон бүр тус тусдаа мөнгөний бодлогын хэрэгжилтийг хангана.

Бундесбанкны Ерөнхийлөгч нь Европын Төв банк (ЕТБ)-ны Удирдах зөвлөлийн гишүүний хувьд мөнгөний бодлогыг тодорхойлоход оролцдог.

3. ХАРИУЦЛАГА

ТӨВ БАНК ХАРААТ БУС БАЙХ ЗАРЧИМ НЬ:

- ЕТБ, түүний гишүүн орнуудын Төв банкуудын хариуцлагын тогтолцооны талаар зохих мэдлэг мэдээлэлтэй боллоо. Төв банкууд, тэдгээрийн удирдлагын шийдвэр гаргадаг зөвлөл, зөвлөлийн гишүүд нь Парламент, Засгийн газар, бусад удирдах байгууллагаас заавар, чиглэл авах ёсгүй бөгөөд авах талаар хүсэлт ч гаргаж болохгүйг хуульчилсан байдаг. Нөгөө талаар Парламент, Засгийн газар, бусад удирдах байгууллага нь Төв банкны бие даасан байдлыг хүндэтгэх үүрэгтэйг мөн хуульчилсан байна. Төв банк нь үйл ажиллагааны тайлан, хэлэлцүүлгийг Парламентад тайлагнадаг. Тухайлбал, ЕТБ.
- Европын Парламентын Эдийн засгийн хороо нь ЕТБ-ны ерөнхийлөгч болон ХЗ-ын дарга нарын мэдээллийг тогтмол сонсдог.

- ЕТБ-ны ерөнхийлөгч болон ХЗ-ын дарга нар Европын Парламентын гишүүдээс бичгээр ирүүлсэн асуултад хариу өгдөг.
- Жилийн тайлангаа Европын Парламентын чуулганаар хэлэлцүүлж гарах шийдвэрийн талаар холбогдох тайлбар, танилцуулга хийдэг.
- Европын Парламентын гишүүдтэй тодорхой мэргэжлийн асуудлаар санал солилцож тайлагнадаг.

ЕТБ-аас бусад зарим орны хариуцлагын системийг бидэнд танилцуулсан. Тухайлбал Английн Төв банк, АНУ-ын Нөөцийн сангийн хүрээнд мөрдөгддөг хариуцлагын тогтолцоог үзүүлбэл:

Английн Төв банк

- Анлийн төв банкны бүтцийн хүрээнд ажилладаг Мөнгөний бодлогын хороо болон санхүүгийн бодлогын хорооны гишүүд нь Их Британий Нийтийн танхим-Парламентын Төрийн сангийн бодлогын хороонд (House of Commons Treasury Committee) тогтмол сонсгол хийнэ.
- Сонсгол нь хамгийн сүүлийн үеийн Инфляцийн тайлан болон санхүүгийн тогтвортой байдлын тайлан зэрэг тодорхой сэдвийн хүрээнд явагдана.
- Төрийн сангийн бодлогын хороо нь Мөнгөний бодлогын хороо болон Санхүүгийн бодлогын хорооны шинэ гишүүдийн томилгооны талаар сонсгол хийнэ. Зорилго нь шинэ гишүүд нь мэргэжлийн ур чадвар болон хараат бус байдлын шалгуурыг хэр хангаж байгааг тогтоодог.
- Зарим томхиолдолд Мөнгөний бодлогын хорооны гишүүд Төрийн сангийн бодлогын хорооны сонсголд жилийн товч тайлан хийнэ.

АНУ-ын Төв банк буюу Холбооны нөөцийн сан

- Холбооны нөөцийн сангийн удирдах зөвлөлийн дарга хагас жил тутамд конгресст тайлангаа тавьдаг.
- Холбооны нөөцийн сан нь хагас жилийн тайлангаа АНУ-ын Конгрессын Сенатын танхимын, Орон сууц, хот байгуулалтын


хороонд, түүнчлэн Төлөөлөгчдийн танхимын Банк, санхүүгийн үйлчилгээний хороонд өгнө.

ЕТБ, түүний гишүүн орнуудын Төв банкууд, банк санхүүгийн байгууллагуудын аюулгүй, найдвартай ажиллагаанд онцгойлон анхаарал тавьдаг бөгөөд энэ талаар Европын Парламент болон Европын холбооны зөвлөлийн өмнө хариуцлага хүлээдэг. Тухайлбал, ХЗ-ийн дарга нь банкны хяналтын тайланг Европын парламент, Европын холбооны зөвлөл, Европын комисс, гишүүн орнуудын Үндэсний парламентад хүргүүлж, мэдээлэл, сонсгол тавьж, асуултанд хариулах хуулийн заалттай. Нөгөө талаас Европын парламент өөрийн санаачлагаар Банкны холбооны тайланг танилцуулдаг.

4. ДҮГНЭЛТ

Дор дурдсан дүгнэлт, саналыг ажил хэрэгтээ цаашид ашиглах боломжтой гэж үзлээ. Үүнд:

1. Ихэнх Төв банк, түүний дотор ЕТБ, ХБНГУ-ын Төв банкны үйл ажиллагааг Гүйцэтгэх зөвлөл нь (бие даасан зургаан гишүүнтэй) удирдаж эцсийн шийдвэрийг гаргаж байна. Хуулиар Парламент, Засгийн газраас зааварчилгаа, зөвлөгөө өгөхийг хориглосон байгаа нь бие даасан байдлыг эрхзүйн хувьд баталгаажуулжээ.
2. Төв банкуудын дотоод хяналтыг хамтын удирдлагын байгууллага болох Хяналтын хороонд авч үзэж дүгнэлт гарган төсөв, төлөвлөгөөг тусгайлан баталж байгаа нь дотоод хяналтыг банкны гүйцэтгэх удирдлагаас ангид байлгахад нөлөөтэй байна.
3. Банкны Гүйцэтгэх удирдлагын тайлан, сонсгол, хэлэлцүүлгийг Парламентын холбогдох байнгын хороод, нэгдсэн чуулганаар хэлэлцэж дүгнэлт гаргадаг механизмыг хуульчилсан байна.
4. Засгийн газар, Парламент нь Төв банкны бие даасан байдлыг хүндэтгэж, хөндлөнгөөс заавар зөвлөгөө өгөхгүй гэдгийг хуульчилсан байна.
5. Засгийн газар нь Төв банкны мөнгөний бодлогод дэмжлэг үзүүлж цалин хөлс, үнийн асуудлаар Төв банкны тавьсан зорилтыг хангахад чиглүүлэн үйл ажиллагаа явуулна гэдгийг хуульчилсан.
6. Төв банкууд нь банк, санхүүгийн байгууллагын хяналтад онцгой анхаарал тавьж мэргэжлийн байгууллага болох Хяналтын хороогоор хөндлөнгийн хяналт тавьж байна. Төв банкны хамгийн чухал үүрэг болох банк, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах үүргийг тус хороо өөр дээрээ авахгүй ч гэсэн хөндлөнгийн хяналтыг тавьж Төв банкны хариуцлагыг өндөржүүлж байгаа хэрэг гэж үзэж байна. Жишээ нь Германд гэхэд арилжааны банк, санхүүгийн бүх үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг шалгадаг хоёр том байгууллага бий. Нэг нь Төв банканд, нөгөө нь Сангийн яамны удирдлагад ажиллаж байна. Энэ хоёр нь өрсөлдөж, хэн сайн шалгалт хийдэг гэдгийг харуулахын хамт хамтран ажиллах үүрэгтэйгээс гадна Германы санхүүгийн системийн найдвартай, аюулгүй байдлыг хангаж, дампуурлаас бүрэн хамгаалж чадаж байна гэсэн дүгнэлт хийж байна лээ. Германы Төв банк болон мужийн салбаруудын ажлын дийлэнх нь банк, санхүүгийн системийн найдвартай ажиллагаанд төвлөрч байна.
7. Төв банк зээлийн барьцаанд авах аливаа үнэт цаасууд нь найдвартай байна гэдгийг хуульчилсан бөгөөд Засгийн газрын заавраар аливаа үнэт цаас авахыг хориглодог хуулийн заалттай.
8. ХБНГУ-ын Төв банкинд гадаад валютын 3,000 еврогоос дээш бүх гүйлгээг мэдээлдэг ба тус банк валютын нөөцийн удирдлага, түүний дотор хөрөнгө оруулалтын багц, валютын нөөцийн удирдлагыг хийж төлбөрийн тэнцлийг гаргаж, статистикийн үйлчилгээ үзүүлдэг.
9. ХБНГУ-ын Төв банк ба бүс нутгийн салбар нь компаниудын хөрөнгийн үнэлгээг хийдэг байна.
10. ХБНГУ-ын Төв банк, Сангийн яам, Татварын албаны төлөөлөл оролцсон Төсвийн орлогын тооцооллын хороо (комисс) ажилладаг байна.



ЗЭЭЛИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Зээл
гэж юу вэ?

Санхүүгийн байгууллага, хувь хүнээс өөрийн хэрэгцээ болон бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтыг тодорхой хугацаатай, хүүтэй, эргүүлж төлөх нөхцөлтэй авахыг зээл гэж энгийнээр тодорхойлж болох юм.

Хэрэглээний зээл

- ✓ Цалингийн зээл
- ✓ Өрхийн зээл
- ✓ Тэтгэврийн зээл
- ✓ Хадгаламж барьцаалсан зээл
- ✓ Ногоон зээл
- ✓ Хөнгөлөлттэй нөхцөл бүхий ногоон зээл
- ✓ Аяллын зээл
- ✓ Автомашины зээл



ЗЭЭЛИЙН ҮНДСЭН 2 ТӨРӨЛ

Бизнесийн зээл

- ✓ Оффисын зээл
- ✓ ПОС-н орлого барьцаалсан зээл
- ✓ Үйлчилгээний талбайн зээл
- ✓ Худалдаа эрхлэгчийн зээл
- ✓ Зээлийн шугам
- ✓ Тоног төхөөрөмжийн зээл
- ✓ Хөрөнгө оруулалтын зээл
- ✓ Эргэлтийн хөрөнгийн зээл



Үндсэн зээл: Зээлийн хүү, шимтгэл ороогүй зээлийн үлдэгдэл дүн.

Зээлийн хүү: Зээлийг тодорхой хугацаанд ашигласныхаа төлөө зээлдүүлэгчид төлж буй төлбөр.

Нэмэгдүүлсэн хүү: Зээлийг эргэн төлөгдөх хуваарийн дагуу төлөх төлбөрөө хугацаа хэтрүүлсэн тохиолдолд үндсэн зээлийн хүү дээр зээлийн тодорхой хувийг нэмж төлж буй хүү юм.

Зээлийн хугацаа: Зээлийн гэрээгээр тохиролцсон зээл авснаас эхлэн төлж дуусах хүртэлх хугацаа.

Зээлдэгч, хамтран зээлдэгч: Зээлийн гэрээний үүргийг хамтран гүйцэтгэх үүрэг хүлээсэн иргэн, хуулийн этгээд.

**ЗЭЭЛ АВАХАД ЮУГ
АНХЛАРАХ ЁСТОЙ ВЭ?**

- Зээлийн хэрэгцээ шаардлага буюу зориулалт тодорхой байх
- Зээлээ эргэн төлөх арга зам нь тодорхойлогдсон байх
- Зээлийн нөхцөл /зээлийн хэмжээ, хугацаа, хүү/ нь зээлийн зориулалтад тохирсон байх
- Зээл нь зөвхөн зардлыг бус ирээдүйн ашиг, орлого, зохистой хэрэглээг санхүүжүүлж байх

Зээлийн эргэн төлөгдөх хуваарь:

Зээлийн хугацааны туршид зээл, түүний хүүний төлбөрийг тодорхой давтамжтайгаар хэсэгчлэн төлөх үүргийг тохиролцсон хуваарь

Хөнгөлөлтийн хугацаа: Бизнесийн онцлог болон зээл эргэн төлөх орлогоос хамааран үндсэн зээлийн төлбөрийг төлөх үүргийг хойшлуулж, тодорхой хугацаанд зөвхөн хүүний төлбөр төлөх хугацаа

Зээлийн урьдчилсан төлөлт: Зээлийн төлбөрийг хуваарьт хугацаанаас нь өмнө үндсэн зээлийг хэсэгчлэн болон бүтнээр нь буцаан төлөх



**ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ БА ТҮҮНЭЭС ХЭРХЭН
СЭРГИЙЛЭХ ВЭ?**

Эрсдэлийн төрлүүд:

- Бизнесийн эрсдэл
- Зах зээлийн эрсдэл
- Үйл ажиллагааны эрсдэл
- Хууль эрх зүйн эрсдэл

Зээлийн эрсдэл нь зээлдэгч банкт байгуулсан зээлийн гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсны улмаас үүсэх алдагдал юм. Та юун түрүүнд өөрөөс хамаарах зүйлсийг хянаж чадснаар эрсдэлээс тодорхой хэмжээнд хамгаалах боломжтой болно.

Эрсдэлээс сэргийлэх аргууд:

- Сар бүр төлөх зээлийн хэмжээг өөрийн цэвэр орлоготой уялдуулан тооцох
- Өөрийн хэрэгцээ, шаардлагад тохирсон нөхцөлтэй зээлийг сонгох буюу зээлийн бүтээгдэхүүнээ зөв сонгож авах
- Зээлээ төлөвлөгөөнийхөө дагуу зөв ашиглан зарцуулах
- Хувь хүн, байгууллага аль аль нь тодорхой хэмжээний сан, нөөцийг үүсгэж хуримтлуулах.



**ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРИЙН
ЯМАР ХЭЛБЭРҮҮД БАЙДАГ ВЭ?**

- Сар бүрийн тэнцүү төлбөр = Зээлийн хүү + Тодорхой хэмжээний үндсэн зээлийн төлбөр
- Сар бүрийн тэнцүү үндсэн зээлийн төлбөр = Үндсэн зээлийн төлбөр + Зээлийн хүү
- Сар бүр зээлийн хүү + тодорхой саруудад үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөж, бусад хугацаанд зээлийн төлбөр тэнцүү
- Сар бүр зээлийн хүү + тодорхой саруудад үндсэн зээлээ хувааж төлөх

Барьцаа хөрөнгө гэж юу вэ?

Зээлийн гэрээний үүрэг биелэхгүй байх нөхцөл ирээдүйд бий болох үед гэрээний үүргийг гүйцэтгүүлэх зорилготой хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, бусдын өмчлөлд шилжүүлж болох эрх.

Барьцаа хөрөнгийн 3 төрөл

- Үл хөдлөх хөрөнгө
- Хөдлөх хөрөнгө
- Биет бус хөрөнгө

ЗЭЭЛ АВАХАД ГАРАХ 3 ЗАРДАЛ

Өргөдлийн хураамж

- Анх зээлийн хүсэлт гаргахад 1 удаа төлдөг 5000-15000

Зээл олголтын шимтгэл

- Зээлийн шийдвэр гарсны дараа зээл олгоход 1 удаа төлдөг зээлийн дүнгийн 0.5-1 хувьтай тэнцэх хураамж

Нотариатын зардал

- Гэрээний үнийн дүнгээс хамаарч зардал харилцан адилгүй байдаг

НИЙТЛЭГ ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД



ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛ

Орон сууцны зээл нь тогтмол орлоготой аливаа иргэнд амьдран суух зориулалтаар орон сууц худалдан авахад нь зориулж банкнаас олгож буй зээлийг хэлнэ. Орон сууцны зээлийг ихэвчлэн 10-30 жилийн хугацаатай олгодог.



Цалингийн зээл

Цалингийн зээл нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажиллагсад зориулсан, зээлийн төлбөрөө ирээдүйн цалин, түүнтэй адилтгах нөхөн олговрын орлогоороо эргүүлэн төлөх нөхцөл бүхий зээлийг хэлдэг. Монголд тус зуучлалын үйлчилгээг үзүүлдэг нийт 12 Арилжааны банк байдаг. Эдгээр байгууллагын зээлийн нөхцөл, хүү, хугацаа, үнэлгээ зэрэг нь тус тусын онцлог, давуу талуудтай байдаг учир та өөрт тохирсон үйлчилгээг сонгох нь чухал.

ТА ЗЭЭЛ АВАХАД БЭЛЭН ҮҮ?

Зээл авахаасаа өмнө та худалдан авахаар төлөвлөж буй зүйл тань хэр хэрэгцээтэй эсэх, хэрэв хэрэгцээтэй бол зээл авалгүйгээр худалдан авах өөр арга зам буй эсэхийг судалж эргэцүүлэх нь зүйтэй. Үүнд таны худалдаж авахаар төлөвлөж буй зүйл үнэхээр хэрэгтэй юу, мөн та тухайн зүйлийг хэрэгцээтэй, эсвэл хүссэн учраас худалдан авах гэж байна уу гэж өөрөөсөө асуугаад үзээрэй.

Мөн зээл авах гэж буй тохиолдолд тухайн зээл "сайн" зээл эсэхийг нягтлах буюу танд богино хугацаанд мөнгө олох боломжийг олгох, урт хугацаанд орлого олох боломжийг тань нэмэгдүүлэх, эсвэл танд зайлшгүй чухал зүйл, жишээ нь орон байр худалдаж авахад тань туслах зээл мөн эсэхийг тодруулах нь зүйтэй. Харин муу зээл гэдэг нь танд төдийлөн шаардлагагүй, ирээдүйд танд орлого олоход туслахгүй зүйл худалдан авахыг хэлнэ.



WWW.SANKHUUGIINBOLOVSROL.MN